

## Монголчуудыг дэлхий "Хуц" гэв -1

Одоо "Эрдэнэт"-ээс болоод Монголын нэр хүндийн уналт эрчээрээ явж өглөө. > 4

## Ярилцдаггүйн уршиг

Сэтгэл гутралын улмаас амиа хорлосон өсвөр үеийнхний 75 хувь нь эрэгтэй. > 7

## Инфляцийн өсөлт үргэлжилнэ

АХБ: Монголын эдийн засаг 2.5 хувиар өснө. > 11



NATIONAL NEWS CORP | БҮРЭГДЭХҮҮН КОМПАНИ

ZASAG.CO



# МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН

# ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

~ THE OFFICIAL GAZETTE ~

2017.04.07, БААСАН ~ №064 (610)

ҮНЭ: 600Т

## ОНЦЛОХ

### УЛС ТӨР

**Ерөнхий сайд татвар аж ахуйн нэгжид хамааралтай хэмээн онцлов.**  
**Элчин сайд М.Такаока 850 сая ам.долларын зээл олгохдоо эрэлтийг харгалзана гэлээ.**  
**Ерөнхийлөгчийн сонгуультай холбогдуулан гадаадад 46 салбар комисс байгуулна.**  
**ЭМ-ийн сайд Түлэнхийн төвийг 2017 оны эцсээр ашиглалтад оруулахаа амлав.**  
**Азийн сайд нарын бага хурал Улаанбаатарт эхэллээ.** Хурлаар гамшгийн талаар хэлэлцэх аж.

### ЭДИЙН ЗАСАГ

**Татварын орлого энэ оны эхний гурван сарын байдлаар 30 хувиар давж биелэв.**  
**Монголбанк валютын дуудлага худалдаагаар 29.9 сая ам.доллар худалдаж авлаа.**  
**Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 1.5 их наяд төгрөгт хүрчээ.**  
**Орон нутаг дахь ипотекийн зээлийн үлдэгдэл 921.1 тэрбум төгрөгт хүрэв.**  
**АНУ-ын үйлчилгээний салбарын индекс буурч, 55.2 нэгж болов.**

### НИЙГЭМ

**Өрхийн амьжиргааны түвшин** тогтоох судалгаа хийхэд нэг айлд 7500 төгрөг зарцуулжээ.  
**Зүүн аймгуудаар малын** гоц халдварт шүлхий өвчний голомт дахин сэдэрлээ.  
**ШЕЗ-өөс "С.Зоригийг** хөнөөсөн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй" гэж мэдэгдэв.  
**Дархан цаазат Богдхан ууланд** золбин нохой олширсныг хамгаалалтын газрынхан хэллээ.  
**Монголын транзит урсгалыг** нэмэгдүүлэхээ БНХАУ-ын төлөөлөгчид ЗТЯ-нд дуулгав.

### ДЭЛХИЙ

**Өмнөд Солонгос өөрийн** баллистик пуужинг туршсан байна.  
**Хятад, Энэтхэг, Индонез** улсууд дэлхийд тамхидалтаар тэргүүлжээ.  
**Атлантын далайн хойд бүсэд** 400 мөсөн уул бөөгнөрсөөс усан зам аюултай боллоо.  
**НАСА-гийн 57 настай сансрын** нисэгч эмэгтэй П.Уитсон тойрог замд 10 сар аялна.  
**НҮБ амжилтад хүрэхгүй бол** АНУ, Сирид өөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээ мэдэгдэв.

## ЦАГ АГААР

### УЛААНБААТАР

2017.04.07



7° -3°

ҮҮЛШИНЭ

ЦАГ АМАРЫН ДЭГЖИРГЭГҮЙ МЭДЭЭГИЙГ 8 ДУГААР НҮҮРЭЖЭЭ УНИШНА УУ.



Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

# Гаалийн албан татварыг нэмж 413.8 тэрбум төгрөгт хүргэнэ



Сангийн сайд Б.Чойжилсүрэн "Өмнө нь төсөвт суулгалгүй зарцуулсан 2.3 их наяд төгрөгийн зардлыг тусгахаар алдагдал өссөн" гэв. ▶2

С.Батсайхан / ЗГМӨ

## НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

### Монгол төрийг амьгүй албатууд нь муухай харагдуулж байна

Г.Илч  
ЗГМ

Он удаан жил хэмжээгүй ихээр идэж уусан, хэрэгтэй, хэрэггүй болгоныг тамтаггүй өндөр үнээр шахаж гаршсан этгээдүүд хувийн өмчийг хууль бусаар булааж авсан ч ханаж цадсангүй. Аргагүй л олон жил хумсалсан гэхээрээ балын амтанд орсон зөгий мэт донтжээ. Харийн өмчлөлд байсан хувийг Монголынх болгож авчирсанд нь дэмжлэг үзүүлэх бус төрийн өмчлөлд шилжүүлж буй нэрээр цөөн тооны төрийн түшмэд гартаа оруулсан нь иргэдийн дургүйцлийг

илт хүргэлээ. Ялангуяа хувийн хэвшил, бизнесийн салбарынхан энэ үйлдлийг эсэргүүцж буй.

Үүнийг удирдсан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осор олон нийтийн эгдүүцлийг хүргээд байна. Тэрбээр уржигдархан хийсэн хэвлэлийн хурлаараа олны бухимдал, зөвүүцлийг зэрэг хүргэв. Гэтэл төрийн дээрмийг удирдаж, түмний өмчөөр тоглож буй энэ эрхэм тоосон шинжгүй, толгой дээгүүр, бүр сэтгүүлчдийг загнаж, зандасан авираар дарамталж явна.

▶3

## ХҮМҮҮС

### Дуурийн сайхныг мэдэрсэн хүн заавал дахиж ирдэг

Г.Баярсайхан  
@bayarsaikhanZGM

Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын туслах найруулагч, урлагийн гавьяат зүтгэлтэн Е.Сарантуяаг "Хүмүүс" булангийнхаа хүндэт зочноор урилла. Болгарын урлагийн сургуулийг төгссөн тэрбээр анх театрт дуулаачаар ирж байсан ч багшийнхаа зөвлөсний дагуу туслах найруулагч болж, энэ мэргэжлээрээ 30 гаруй жил ажиллажээ. Сарантуяа 60 насны босго давсан хэдий ч өөрийн мэддэг чаддаг бүхнийг залуу үедээ зааж сургахын тулд театртаа ажилласаар байна.

-Та манай уншигчдад өөрийгөө танилцуулна уу?  
-Би 1982 онд Болгар улсад

хогжмийн дээд сургууль төгсөөд ДБЭТ-т ирснээс хойш өнөөдрийг хүртэл ажиллаж байна. Уг нь 1973 онд Дундговь аймагт аравдугаар ангиа төгссөний дараа Санхүүгийн техникумд элсэн орж, нягтлан бодогч мэргэжлээр төгссөн юм. Дараа нь хоёр жил нутагтаа нягтлан бодогчоор ажилласан. Гэтэл сайн дурын уран сайханчдын улсын анхдугаар уралдаан гэж боллоо. Түүнд амжилттай оролцсон хүмүүсээс шалгаруулж, Болгар руу сургуульд явуулахад би тэнцсэн юм. Ингээд нэг мэдэхэд урлагийн хүн болсон доо.

Гэхдээ би дунд сургуульд байхдаа дуулдаг, концертонд тасралтгүй оролцдог, тэр хавьдаа л од хүүхэд байсан юм уу даа.

▶5

## НЭЭЛТТЭЙ ЗАХИДАЛ

CEO клуб 2017 он 4 сарын 7

**УИХ-ЫН ДАРГА М. ЭНХБОЛД ТАНАА,**

Монголын Гүйцэтгэх захирлуудын клуб буюу CEO Club нь Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын 2017 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн мэдэгдлийг дэмжиж эдийн засгийн энэ эгзэгтэй үед хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг нэмэх, тэтгэврийн насны босгыг өсгөхийг эрс эсэргүүцэж байгааг мэдэгдэж байна.

ОУВС-гийн зүгээс эдийн засгийн уруудалтыг зогсоож, өсөлтийг хангах бодлогыг гаргаж, төсвийн орлогоо төрөлжүүлэх, нэмэх, төсвийн зардлаа хумин тогтвортой түвшинд аваачихыг нөхцөл болгосон бол хамгийн эхний ээлжинд үргүй зардлаа танах бус харин иргэдийнхээ, татвар төлөгчдийнхөө татвар, шимтгэлийг нэмэх сонголтыг Засгийн Газар гаргаж байгаад бид харамсч байна.

Төсвийн алдагдлыг нөхөхийн тулд төрийн өмчит компаниудын удирдлагад орлогоо нэмэгдүүлэн зардлаа хэмнэхийг даалгаж, улсад төлдөг татвар, ногдол ашгийн төлөвлөгөөг гаргуулан баталж, төсөвт суулгахыг УИХ-ын гишүүдэд уриалъя!

Тэтгэврийн сангийн өрийг барагдуулахад төрийн өмчит компаниудын хувьчлалаас орох орлогыг хуваарилж, асуудлыг нэгмөр шийдвэрлэн тэтгэврийн тогтолцооны реформыг хийж эхлэхийг санал болгож байна. Шинэчлэлийг хийх цаг нь ирсэн гэдэгтэй бид санал нэг байгаа. Бусад улсын жишгээр төрийн өмчит компаниудыг улсынхаа тэтгэврийн санд балансаар шилжүүлэн өгснөөр энэ шинэчлэлийг хийх нэгэн гарц байсаар байгаа.

Төрийн өмчит компаниуд хувийн компанитай өрсөлдөх нь өөрөө шуудрага бус тул тэднийг хувьчлах төлөвлөгөөг гарган баталж, харин төрд байх хугацаанд тэдний үр ашгийг, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд ТУЗ-ийг хараат бусаар ажиллах боломжоор хангахыг бид танаас хүсч байна. Хараат бус гишүүдийн квотыг барин ажиллахад бид хамтран ажиллахад бэлэн байгааг мэдэгдье.

Иргэдийн амьжиргааны гол эх үүсвэр болсон цалин тэтгэмж 2012 оноос хойш дорвитой нэмэгдээгүй, төгрөгийн худалдан авах чадвар үлэмж хэмжээгээр доройтож, дундаж иргэдийн орлого амьжиргаанд хүрэхгүй болсон, баялаг бүтээн ажил олгож, ачааны хүндийг үүрч ирсэн бизнес эрхлэгчид туйлдаж байгаа энэ үед та бүгд мэргэн ухаан гаргаж зөв шийдэл гаргана гэдэгт бид найдаж байна.

Бидний энэ санаачлагад нэгдэхийг бусад бизнесийн холбоод, иргэний нийгмийн байгууллагууд, иргэд, аж ахуйн нэгжүүдэд уриалж байна.

Өөрийн удирдаж байгаа нийт баг хамт олны өмнөөс  
Гүйцэтгэх захирлуудын клубын гишүүд

CEOCLUB.MN | INFO@CEOCLUB.MN | 976-7707-8080, 8885-8983  
"АРД ХОЛДИНГС"-ЫН БАЙР 2 ДУГААР ДАВХАР ЕРӨНХИЙ САЙД АМАРЫН ГУДАМЖ, СҮХБААТАР ДҮҮРЭГ, УЛААНБААТАР ХОТ, МОНГОЛ УЛС

<b>MSE ALL</b> 851.63 2.88%	<b>АЛТ</b> 1251.30 0.33%	<b>ЗЭС</b> 5895 2.00%	<b>10-ЧИНГИС БОНД</b> 94.860 0.04%	<b>5-ЧИНГИС БОНД</b> 99.960 0.04%	<b>АМ.ДОЛЛАР</b> 2435.25	<b>ЮАНЬ</b> 353.06	<b>РУБЛЬ</b> 43.17
-----------------------------------	--------------------------------	-----------------------------	--	---	-----------------------------	-----------------------	-----------------------



## Нийтлэлчийн булан

# Монгол төрийг амьгүй албатууд нь муухай харагдуулж байна

**Өөрийн автортой дээрмийнхээ хариуцлагыг хүлээхгүй хэмээн гүрийж байна**

◀

Бас өөрийгөө хэлмэгдсэн хүн хэмээн уйлагнаж харагдана билээ. Төрийн мөнгийг “хэмнэсэн” хэмээн цээжээ хоосон дэлдсэн түүнийг хэвлэлүүд гүтгэсэн гэж тун хонзонтой мэдэгдэж суусан.

Өнгөрсөн мягмар гарагт “Эрдэнэт” үйлдвэрийн удирдлагуудын нууцлаад байсан цалингийн мэдээлэл ил болж, нэлээд шуугиан тарьсан. Тус үйлдвэрийн гүйцэтгэх захирлын цалин 25 сая төгрөг буюу 10 мянган ам.доллар болохыг хэвлэлүүд мэдээлсэн юм. Гэтэл үүнийг илт ташаа мэдээлэл гэж нулимаад, цалингийн хэмжээ нь 25 биш 24.5 сая төгрөг хэмээн цамнаж гарсан. Хөөрхийг хэвлэлийнхэн үнэхээр “хэлмэгдүүлжээ”. Бүхэл бүтэн 500 мянган төгрөгийн зөрүүтэй мэдээлсэн байна. Тиймээс тэрбээр гүтгэсэнд гомдож, тунирхан, “Би худалч, хулгайч, хумслагч, хувааж идэгч биш” хэмээн шүлс үсэргэн, цамналаа.

Ингээд зогссонгүй. “7000-8000 хүн удирддаг, дэлхийн хэмжээний компанийн гүйцэтгэх захирлын цалинг бодож, 10 мянган ам.доллар болгосон. Харин ч бага тогтоож, хангалттай хэмнэсэн. Тухайн үед “Монголын зэс” корпорацийн удирдлагууд хэтэрхий их байна гэсэн санал тавьж байсан л даа. Гэхдээ энэ бол маш бага мөнгө” хэмээн даапаалав. Ямар юм үзсэн баян эрхэм бэ. Түүний хэлж буйгаар жилийн 290 гаруй сая төгрөгийн цалин өгч, “Эрдэнэт” үйлдвэрийн гүйцэтгэх захирал Х.Бадамсүрэнг нэлээд “чангалж”



Хэдхэн сарын өмнө төрийн тансаглалыг танана хэмээн том дуугарч байсан энэ эрхэм одоо хасалтын хойноос харуусч байна.

байгаа аж. “Өмнөх захирлуудыг бодвол Х.Бадамсүрэн зайлуул, хангамжаа хасуулж хохирч байгаа хүн” хэмээн ярилцлагадаа дурдаад, өмнөөс нь бараг нулимс унагаж дөхөв.

Хэдхэн сарын өмнө төрийн тансаглалыг танана хэмээн том дуугарч байсан энэ эрхэм одоо хасалтын хойноос харуусч, хэдэн саяар хэмжигдэх мөнгийг шалихгүй мөнгө хэмээн даажигнаж буй. Төрийн өмч тойрсон мөнгөний үнэр, дарга дагасан эрх мэдлийн хүч түүнийг хэдхэн сарын дотор

танигдахын аргагүй болтол нь төрөл арилжуулсан бололтой.

Сая, саяар нь шахаа хийж, саасан мөнгөө салаагаар урсгадаг төрийн “бирлүүд” өнөөдөр монгол өрхийн төсвийг цоолчихоод байгаа нь нүцгэн үнэн. Төмөрийн гэр бүлээс эхлээд төрийн тэргүүн хүртэл төсвөө 60 дахин танаж буйгаа тайлагнаж байгаа. Бүсээ тасартал чангалж, зардлаа тултал танаж буй ард түмэн, хувийн хэвшлийнхээ өмнөөс “10 мянган ам.доллар бол маш бага мөнгө” хэмээн чамлаж буй энэ хурган даргад

ичих нүүр алга. Ичих нь бүү хэл, инээд алдан энэ үгээ хэлсэн нь олны дургүйцлийг үнэхээр төрүүлж байна. Засгийн газар төрийн тансаглалтай дайн зарлаж, тэвчиж болох зардлыг бууруулахаа амласан. Гэтэл энэ амлалтыг доод шатныхан хэрхэн хэрэгжүүлж, ядарсан ард түмнээрээ тохуурхаж буйг цадиггүй дарга нарын цайрсан үйлдлээс харж болно. Нөгөөтэйгүүр, Засгийн газрын бодлогыг энэ нөхөр уландаа гишгэж, нийгэмд буруу ойлголт цацаж байгаагаа ч мэдэрч байгаа

юм алга.

Хэмнэлт, гамналтад уургаа хад шиг ханддаг төрийн түшээд түмний өмч рүү дайрч, төрийн албыг самрахдаа харин уургын морь шиг уулгалан довтолдог. Өнгөрсөн мягмар гарагт “Эрдэнэт” үйлдвэрийн ТУЗ-ийн хурлыг Ц.Ням-Осор даргын тушаалаар хийсэн. Хувийн өмчийг хулгайлсан, түшмэдийг доргиосон халаа сэлгээ бас түүний заавраар хэрэгжсэн. “Эрдэнэт”-ийг донсолгосон энэ халаа солиог ч тэрбээр тоосон шинжгүй бүр өөгшүүлж, эрхлүүлж байна. Энэ их хямралын үед компанийн захирлуудыг олон зуун сая төгрөгийн үнэтэй, тансаг машин тэргээр гоёж, толгойг нь илэхдээ тун сурамгай ажиллаж сурчээ.

### Хувийн хэвшилд харгис ноён, догшин сахиус адил төрийн олигархуудын өмнө утсан хүүхэлдэй мэт

Бас “хөөрхөн жүжигчин”. Хэмнэлтийн горимд шилжүүлж, цомхон бүтцийг хэрэгжүүл хэмээн даалгасан гэж даруухан дуугарч байна. Гэтэл даалгасных нь дагуу ТУЗ-өөс “Эрдэнэт” үйлдвэрийн орлогч захирлын орон тоог хоёрдоо өсгөж орхисон нь түүний хийсэн “хэмнэлт”. Ийн түмний хөрөнгийг самарч, төрийн албыг данхайлгахдаа өөрийнхөө халаасыг ч мартсангүй. ТУЗ-ийн гишүүд тэргүүтэй албаны 20-иод хүнийг өөрийн эзэмшлийн зочид буудалдаа тухалж, хаялгатай загнахыг даалгасан бололтой. Орхон аймагт байрлах түүний “Сэлэнгэ” буудалд тэд 20 хоног “Эрдэнэт”-ийн мөнгөөр тарвалзсан нь тохиолдлынх явч биш. Манай улсын эхний гуравт

бичигддэг энэ том хотод түүний хувийн буудлаас өөр очих газар олдохгүй баймааргүйсэн. Энэ талаар түүнээс тодруулахад “Ийм жижиг сажиг зүйл ярьж надаар бүү оролд. Би тэр буудлын ердөө 20 хувийг эзэмшдэг” хэмээн жишим ч үгүй хэлж байна билээ. Түүний хувьд энэ тун жижиг зүйл гэнэ. “Би хумсалдаггүй, хулгайлдаггүй” хэмээн шударга царайлан жүжиглэх түүний бодит төрх энэ.

Үүгээр зогсохгүй өөрийн автортой энэ хэргийнхээ хариуцлагыг хүлээхгүй хэмээн гүрийж байна. “Эрдэнэт” үйлдвэрийг төрийн эзэмшилд авсныг олон улсын Арбитрын шүүх буруутай гэж үзвэл хэн хариуцлага хүлээх вэ гэсэн сэтгүүлчдийн асуултад тэрбээр “Би биш Монголын төр л хариуцна. УИХ, Засгийн газраас төрийн мэдэлд ав гэсэн даалгавар өгсөн. Төрийн эрх барих дээд байгууллага УИХ-ын эрх баригч гишүүд мэдэж, шийдвэр гаргасан. Тиймээс Монголын төр хариуцна. Би бол зүгээр л гүйцэтгэгч. Санаа зоволтгүй” хэмээн жинхэнэ утсан хүүхэлдэй гэдгээ зарлаж, Монгол Улсын Ерөнхий сайдын өгсөн үүргийг хөлдөө чирсэн. Ичих нүүр, эмээх сэтгэл, эмээглэх ёс зүйгүй төрийн албан хаагчдын бодит дүр төрх нь төрийн өмчийн толгойд суусан энэ эрхэм.

“Эрдэнэт” үйлдвэрийн хувийн эзэмшлийн 49 хувийг төрд шилжүүлэх УИХ-ын тогтоол гарсан. Энэ талаар түүнээс асуухад “Миний хувьд ч хүнд байна. Компаниудтай холбоотой хууль эрх зүйн зохицуулалт өнөөг хүртэл бүдэг, бадаг байгаа. Зальтай, овсгоотой хүн хаана ч тоглож болох тогтолцоо Монголд байгаа учраас ажил хариуцаж буй албан тушаалтанд амаргүй байна. Гэхдээ хууль тогтоох дээд байгууллагаас шийдсэн тул гайгүй байх” хэмээн юу хийж байгаагаа ч сөхөөрч амжаагүй мунгинаж явна.

Хувийн хэвшилд харгис ноён, догшин сахиус шиг аашлах атлаа төрийн олигархуудын өмнө яг л утсан хүүхэлдэй мэт даалгавар биелүүлж яваж хараарай. Тэдэнд төрт ёс, хууль журам, ард түмэн, Монголын эрх ашиг гэх зүйл байхгүй, бүгдийг бяцалж, дарга дагасан ашиг сонирхлыг л зөвхөн дээдлэн шүтнэ. [ЗГМ]

Б.Ганбаяр / ЗГМ©

# Шилдгүүдийг нэг дороос...



Та доорх кодыг уншуулж Засгийн Газрын Мэдээ Financial Times сонинг нэг дороос уншина уу



Та QR code уншуулахын тулд App Store-оос QR reader татаж суулгана уу.

70103131, 99903581, 99903584  
info@zasag.co  
Zasag.Co



## Хүмүүс

# Е.Сарантуяа: Дуурийн сайхныг мэдэрсэн хүн заавал дахиж ирдэг

*Театрт 35 жил ажилласан хэрнээ одоо хүртэл суралцаар л явна*

◀

Өөрөө ч урлагт сонирхолтой байсан болохоор боломжийг алдахыг хүсээгүй.

Би дуурийн театрт дуучнаар цөөхөн жил ажиллаад туслах найруулагч болсон. Энэ үеэс хойш олон жүжигт туслах найруулагч хийлээ. Мөн 1991 оноос хойш улсын баяр наадмын концертод туслах найруулагчаар ажилласан. Төрийн концертод ажиллана гэдэг уран бүтээлч хүний хувьд нэр төрийн хэрэг. Олон мундаг найруулагчийн туслахаар ажилласных их зүйл сурч, туршлага суусан даа.

Уг нь би тэтгэвэрт гарах нас аль хэдийнэ өнгөрсөн хүн. Гэвч театрын боловсон хүчний асуудал хүндхэн болохоор намайг байлгаад байгаа юм. Орос руу хоёр, гурван хүн сургуульд явсан. Тэднийг төгсөж иртэл ажиллах ёстой. Дуурийн театраа хэрэг болж л байвал зүтгэхээс яхав.

**-Дуурийн дуучин хүн яагаад найруулагч болсон юм бэ?**

-Туслах найруулагч хийж байсан Б.Жаргал эгч өндөр насныхаа тэтгэвэрт гарах болоод намайг орондоо ажиллаач гэсэн санал тавьсан юм.

**-Туслах найруулагч хүн яг юу хийдэг юм бэ?**

-Тайзнаа тоглож байгаа бүх л жүжиг, дуурийн арын албыг хариуцна. Ерөнхий найруулагчийн дэглэсэн жүжгийг цааш нь авч явдаг хүн бол туслах найруулагч. Дублёруудаа бэлдэнэ, гэрлээ тааруулна, тайз солигдох, жүжигчид хэзээ орж, гарах гээд бүгдийг зохицуулах үүрэгтэй. Тиймээс асар хариуцлагатай, бүх юмаа мэддэг байх ёстой.

**-Найруулагчийн мэргэжил эзэмшээгүй хүн энэ саналыг хэрхэн хүлээж авсан бол. Айж, эмээж байв уу?**

-Залуу байсан болоод ч тэр үү, чадахгүй байх гэсэн бодол төрөөгүй. Багш маань их туршлагатай хүн байсан. Надад "Чи энэ ажлыг хийж чадна" гэж зоригжуулаад Л.Эрдэнэбулган найруулагч дээр дагуулан очиж байлаа. Сайн хүний удирдлага дор ажлыг зөв эхлүүлбэл бүтдэг л юм билээ.

**-Хийсэн сонголтдоо эргэлзэж, харамсах үе байдаг уу?**

-Байхгүй. Яагаад ийм бардам хэлж байна вэ гэвэл, хэрэв би дуучнаар явсан бол гоц гойд, мундаг болж чадахгүй ч байж мэднэ. Дуурийн дуучин гэдэг шалгуур өндөр шүү дээ. Тиймээс хийсэн сонголтдоо харамсдаггүй. Харин ч Б.Жаргал гуай ийм замаар чиглүүлсэнд баярладаг.

Л.Эрдэнэбулган найруулагч багшийг маань талийгаач болсны дараа "Жаргал гуай билгийн нүдтэй хүн байжээ. Чамайг яаж таньж, өөрийнхөө оронд тавьсан юм бэ" гэж билээ. Багшийнхаа ачийг бага ч гэсэн хариулж, нүүрийг нь улалзуулалгүй яваадаа баярлах юм даа.

**-Өнгөрсөн хугацаанд хэдэн дуурь дээр ажилласан бол. Багцаа тоо байдаг уу?**

-Би эхэндээ сүрхий тооцоолдог байлаа. Харин сүүлдээ тоогоо алдсан. Манай театр 1963 онд байгуулагдсанаас хойш нийт 50 гаруй дуурь тавьсан байдаг. Би үүний 40 гаруйд нь оролцсон байх. Театрт туслах найруулагч хийхээс гадна бусад концертод өөрийнхөө хэмжээгээр оролцоно. Мундаг найруулагчдын удирдлагад ажиллаж, тэднээс ихийг сурсны хүчинд л өдий зэрэгтэй яваа гэж боддог. Гэхдээ туслах найруулагч хүн "Би энэ ажлыг гарын 10 хуруу шигээ мэддэг боллоо. Одоо надад сурах зүйл алга" гэж бодож болдоггүй. Яагаад гэвэл шинэ юм байнга гарч ирнэ. Тэр бүгдээс суралцаж байдаг юм. Би театрт 35 жил ажилласан хэрнээ одоо хүртэл



Б.Ганбаяр / ЗГМФ

суралцаар л явна.

**-Нэг дуурь тавихын тулд хэдий хугацаанд бэлддэг вэ?**

-Манай монголчууд цагийг нь тулгаж байгаад нэг дайралтаар ажлаа амжуулах нь элбэг. Мундаг гэх юм уу, нөгөө талаар хэнэггүй гэх үү. Гадаадын мундаг театрт нэг том дуурь тавихын тулд бүтэн жил бэлдэх үзүүхэнд. Харин бид ихэвчлэн 3-4 сарын хугацаанд бэлдэнэ. Нэг юм хийж байтал дараа долоо хоногийн тоглолт болж, түүндээ бэлдэх гээд бэрхшээл гарна л даа. Тиймээс бэлдэх хугацаа харьцангуй бага. Гэхдээ би театрын уран бүтээлчдээ мундаг гэж хэлнэ. Богино хугацаанд асар том ажлын ард гарч чаддаг.

Одоо манай залуучууд театраа их сайхан авч явж байна. Гадаад харилцаа сайжирлаа. Дуучид маань гаднын том тэмцээнд оролцож, өндөр амжилт үзүүлж байна.

## Хүний гоо зүйн хүмүүжилд сонгодог урлаг асар их нөлөөтэй

**-Монголоос дэлхийн хэмжээний дуурийн дуучин төрж гардаг нь ямар шалтгаантай юм бол. Багш нар сайных уу, эсвэл монгол хүний хоолойны онцлог гэж байна уу?**

-Мэдээж байгалиас заяасан сайхан хоолойтой байж амжилтад хүрнэ. Мөн багш нартай ч холбоотой. Өнөөдөр СУИС-д дандаа монгол хүмүүс багшилж байна. Тэдний ихэнх нь социализмын үед Орос, Болгарт урлагийн сургууль дүүргэсэн хүмүүс. Тэр хүмүүсийн шавь нар өдгөө сайн явна.

Ер нь манай дуучид цаанаа л өөр, бядагтай байдаг. Үүнд нь Монголын эрс тэс уур амьсгал нөлөөлдөг байж магадгүй. Хүмүүс нь улирал бүрт дасан зохицож амьдардаг. Энэ бүхэнтэй холбоотой байх гэж боддог юм.

**-Тавихад хэцүү дуурь гэж байдаг байх. Та ямар дуурийг нэрлэх вэ?**

-Хэцүү эсвэл амархан дуурь байдаг. Тэр ч байтугай тавих дургүй дуурь ч бий. Миний хувьд адармаатай, хэцүү дуурь гэвэл "Дон Жуан"-ыг нэрлэнэ. Жүжигчид нь зүгээр зогсч байгаад дуулах мөч тун ховор. Байнга хөдөлгөөнтэй байх шаардлагатай. Гэрэл нь хэдэн талд зэрэг солигддог. Хөдөлгөөн болгон дээр гэрэл хасч, нэмнэ. Энэ талаасаа "Дон Жуан" дуурь хэцүү санагддаг. Ер нь анх хийж байгаа дуурь болгон хэцүү. Гэхдээ хэд хэд тоглоод ирэхээр гайгүй болно.

**-Айхтар ноцтой алдаа гаргаж**

**байв уу?**

-Бага зэрэг алдаа гаргах тохиолдол байлгүй яахав. Гэхдээ айхтар том алдаа гаргаж байгаагүй ээ. Бид чинь алдах эрхгүй хүмүүс шүү дээ. Тухайн дуурь амжилттай, алдаа мадаггүй болох, эсэх нь туслах найруулагчаас шууд хамаардаг. Хэрэв би алдвал тэр олон хүний хөдөлмөр үгүй болно. Үзэгчдэд ч ямар санагдах нь тодорхой. Чимхлүүр ажил их болохоор юумаа мартаж болохгүй, ой тогтоолт сайн байх хэрэгтэй.

**-Хүмүүс сүүлийн үед дуурь хэр үзэж байна вэ?**

-Манайх долоо хоног бүр өөр дуурь тоглодог. Заримдаа суудлын тал нь дүүрнэ. Гэхдээ ихэнхдээ дүүрэн хүн үзнэ шүү. Ер нь дуурь үзэж, сонгодог хөгжмийн сайхныг мэдрээд гарсан хүн дараа заавал дахиж ирдэг. Тэгсээр байгаад манай байнгын үзэгч болдог. "Бид ойлгодоггүй байж. Дуурь гэдэг чинь ямар гоё юм бэ" гэж хэлэх хүнтэй зөндөө таарч байлаа.

Хэдийгээр гадаад хэл дээр дуулж байгаа ч хоёр талын дэлгэц дээр орчуулга нь гарна. Үүнийг уншиж, ойлгоод ирэхээр гоё сайхныг нь мэдрдэг юм. Одоо сонгодог урлагийг ойлгож, сайхан хүлээж авдаг хүн олон болсон.

**-Залуу үеийг дуурь, сонгодог урлагт дургүй болгохын тулд юу хийх ёстой вэ?**

-Дунд сургуулийн хичээлийн хөтөлбөрт сонгодог урлагийг оруулаар санагддаг юм. Зарим сургууль ангиараа ирж дуурь, балет үздэг. Тэд ямар мундаг ойлгож, дурлаж үздэг гэж санана. Хүүхэд л юм болохоор завсарлагаанаар шуугилдаад байна. Харин яг тоглолт эхлэхээр нам гүм болдог. Тэгэхээр хүүхдүүд сонгодог урлагийг мэдэрч, хүлээн авч чадаж байна гэсэн үг.

Ер нь хүний гоо зүйн хүмүүжилд сонгодог урлаг асар их нөлөөтэй. Оюун ухааныг гэгээрүүлж, үзэл бодолд нь нөлөөлдөг. Тиймээс хүүхдийг урлагаар хүмүүжүүлснээр явч буруудахгүй.

**-Та бүгдийн нийгмийн асуудлыг сонирхмоор байна. Хангалттай цалин авч чаддаг уу. Улсаас үзүүлэх дэмжлэг туслахаа хэр байдаг бол?**

-Үнэнийг хэлэхэд бидний цалин бага шүү дээ. Гэхдээ манайхан гомдоллодоггүй, цалингаа нэмүүлье гэж жагсдаггүй. Бид энэ ажлыг сэтгэл зүрхээрээ л хийж байна. Зарим нь ийм бага цалингаар өчнөөн жил ажилладаг ямар тэнэг юм бэ гэж боддог л байх.

Зах зээлийн нийгэмд шилжээд, хүмүүсийн амьдрал доройтож, үзэгчгүй болсон ч дуурийн театр хаалгаа бариагүй. Өнөөдөр ч гэсэн бага цалинтай хэрнээ ажлаа хийж л байна. Цалин бага болохоор тэтгэвэр ч бага

тогтоогддог юм билээ.

Гэхдээ бид бага цалин авлаа гэж хэзээ ч гутардаггүй. Хийж байгаа ажилдаа сэтгэл хөглөгддөг юм уу даа. Үзэгчдээс ирж буй гоё энергиэс эрч хүч авдаг даа. Яамнаас төсөвлөж өгсөн мөнгө нь ийм болохоор түүндээ тааруулахаас аргагүй. Ер нь ядуу байгууллагын дарга нарын зовлон их байдаг юм

байна. Нэг юм хийе, хэн нэгнийг сургуульд явуулья гэхэд мөнгө байхгүй. Энд тэндээс гуйж босгохоос өөр аргагүй. Гэхдээ хэцүү ч гэсэн болгоод байгааг нь харахаар "Ямар ч хэцүү ажил юм бэ" гэж бодогддог.

Тиймээс төр засаг үүнд анхаарах цаг нь болсон. Одоо урлаг, спортынхон л улсынхаа нэрийг дэлхийд гаргаж байна.


Харин төр засаг спортод арай илүү анхаарал хандуулаад байгаа юм шиг санагддаг. Адилхан амжилт гаргаад ирэхэд адилхан л үнэлэх хэрэгтэй. Яагаад гэвэл урлагийнхан Монгол Улсын нүүр царай болж байдаг. Төрт ёсны баяр болоход урлагийнхан хамгийн түрүүнд дайчлагдана. Гадаадын өндөр хэмжээний айлчлал болоход манай урлагийн хэд л нүүр тахалдаг. Харин жүдогийнхон очоод барилдаад байдаггүй биз дээ. Тамирчдын хөдөлмөр, амжилтыг үгүйсгээгүй шүү. Харин урлагийнхныг арай л бага үнэлээд байна.

**-Та 20 гаруй жил наадмын нээлтэд ажиллажээ. Хэдэн онд хэний найруулсан нээлтийн ёслол хамгийн сайн болсон санагддаг вэ?**

-Олон сайхан ёслол байна даа. Дээхнэ үед нээлтийн ёслол гоё л болдог байлаа. On&Off-ын С.Ононбат нэг жил их дажгүй хийсэн санагддаг. Өмнө нь найруулж байгаагүй болохоор туршлага дутах байх гэж болсон ч аятайхан аваад гарсан. Зарим жил сэтгэлд хүрэхгүй, тиймхэн болох тохиолдол бий. Нодингийнх бол дажгүй болсон.

Уг нь наадмынхаа нээлтийг оройн цагаар хиймээр санагддаг юм. Сүүлийн үеийн техникийн хөгжил, гэрэл ашиглаад янз бүрийн гоё юм хийж болно шүү дээ. Өтөлсөн хойно яагаад ч юм ийм бодол орж ирээд байгаа. Гэхдээ энэ бол миний хувийн бодол шүү.

**-Сайхан ярилсанд баярлалаа. [ЗГМ]**



**СЭЗИС-ийн Ашгийн бус байгууллагын менежментээр мэргэшүүлэх Бизнесийн Удирдлагын Магистр (NPO-MBA)-ын 1 жилийн хөтөлбөрт суралцахыг урьж байна.**

NPO-MBA хөтөлбөр нь дэлхийн сүүлийн үеийн чиг хандлага болох бизнес менежментийг ашгийн бус байгууллагын менежменттэй хослуулсан сургалтыг нэвтрүүлж буй монголд анхдагч MBA хөтөлбөр юм. Мөн интернет ашиглан орон зайнаас үл хамааран дэлхийн аль ч өнцгөөс таны цаг зав боломжид тулгуурлан хамгийн бага зардлаар, хамгийн богино хугацаанд сурч, дипломын хамгаалалтыг онлайнгаар хамгаалах боломжийг нэвтрүүлсэн монголын анхны магистрын хөтөлбөр болж байна.

Энэхүү 1 жилийн магистрын хөтөлбөрт суралцсанаар бизнес менежментийн сургалтыг практиктай илүү түлхүү холбосон мэдлэгийг олж авахаас гадна манлайлах, санхүү менежментийн ур чадвараа дээшлүүлэх, мөн бизнесийн болон бусад салбарт ажиллаж буй суралцагчдын туршлагаас хуваалцах боломжтой.

**Элсэгчдэд тавигдах шаардлага:**  
Магадлан итгэмжлэгдсэн их дээд сургууль төгссөн байх  
Англи хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй  
Бие даан судалгаа шинжилгээ хийх хүсэл сонирхолтой (Төр, ИНБ, ОУБ, АББ-ын чиглэлээр бол сайн). Төр, ОУБ-ууд болон нийгмийн эрх ашгийг хөндсөн төсөл хөтөлбөрүүдэд ажилладаг бол давуу тал болно.

**Бүртгэл:**  
2017 оны 4-р сарын 17-ныг дуустал явагдана.  
Бүртгүүлэх хүсэлтэй хүмүүс өөрийн биеэр ирж (и-мэйл хаягаар бүртгүүлэх хүсэлтээ илгээж болно) бүртгүүлнэ үү.

**СЭЗИС-ийн Иргэний нийгмийн байгууллагуудын чадавхи бэхжүүлэх төв**

**СЭЗИС, "С" байр, 11 давхар, 1104 тоот**  
Утас: 70008198, 99850623, и-мэйл: npom@ufe.edu.mn  
web: www.ufe.edu.mn  
facebook page: www.facebook.com/NonProfitOfMongolia/



## Эрүүл мэнд

### ДЭЛХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ӨДӨРТ

**Сэтгэл гутралын улмаас амиа хорлосон өсвөр үеийнхний 75 хувь нь эрэгтэй**

З.Цэлмэг  
@tselmeg2GM

Өөр хоорондоо сайн ярилцаж байхын ашиг тусыг өнөө жил эрүүл мэндийн салбарынхан дэлхий дахинаа онцолж байна. Нэг нэгнээ тэвчээртэй сонсож, тулгарч буй асуудлаа ойр дотны хүн, эмч, сэтгэлзүйчид дэлгэж, нээлттэй ярилцах нь эрүүл байхын үндэс гэдэгт улс орнууд дуу хоолойгоо нэгтгэж байна.

Хүмүүс хоорондын харилцаа хумигдаж, хурдтай хөгжлийн хэмнэлд бие биенээ гэж завгүй яваагаас эрүүл мэнд, сэтгэл санаагаар хохирч, цаашлаад цаг бусын хагацал зовлонд ч нэрвэгдэх үндэс нь сэтгэл гутрал болж буйг мэргэжилтнүүд анхааруулав.

Сэтгэл гутрал хэмээх үг нийгмийн эрүүл мэндийн хөгжлийн нэг салаа мөчир болж, бидний үгсийн санд нэвтрээд удаагүй байна. Үнэндээ хагас зууны тэртээд хүмүүс сэтгэл гутрал буюу депрессийн талаар ингэж нээлттэй ярилцах хэрэгцээ байгаагүй талаар АНУ-ын Калифорни муж улсын их сургуулийн сэтгэл судлалын профессор Нэнси Панза онцлов.

**Сэтгэл гутрал гэж юу вэ?**  
Байгын уйтгар гунигт автах нь сэтгэл гутралын гол шинж тэмдэг. Мөн жирийн үед баясаж, сэтгэл ханамж авч чаддаг байсан идэвхтэй үйл ажиллагаандаа сонирхолгүй болж, өдөр тутмын амьдралаа ч авч явах чадваргүй болдог. Энэ байдал хамгийн багадаа хоёр долоо хоногээр үргэлжилбэл сэтгэл гутралд орсны шинж.

Сэтгэл гутралд орсон үед эрч хүч буурч, хоолны дуршил өөрчлөгдөж, унтах нь ихсэх, эсвэл багасах, түгших, анхаарал төвлөрөл буурах, яах нь мэдэгдэхгүй байх, тайван бус болох, цаг үргэлж таагүй мэдрэмтэй тээх, өөрийгөө буруутгах, итгэл найдвараа алдах, явандаа өөртөө аюул учруулж, амиа хорлоход хүргэдэг.

#### СЭТГЭЛ ГУТРАЛД ТҮГШИХИЙН УЧИР

Энэ эмгэгээр шаналагчдын тоо жилээс жилд нэмэгдэж байна. Манай гараг дээр сүүлийн гурван жилийн хугацаанд 128 сая хүн сэтгэл гутралд нэрвэгджээ.

Тоон мэдээллээс үзвэл 2013 онд дэлхий дахинаа 615 сая хүн ийм өвчний оноштой байсан байна. Энэ нь 1990 оноос хойш 200 орчим саяар өссөн үзүүлэлт



Б.Ганбаяр / ЗГМӨ

# Ярилцдаггүйн уршиг

болох нь Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (НЭМҮТ)-ийн гарын авлагад тов тодорхой байна.

Сэтгэл гутрал бол эмчилж, урьдчилан сэргийлэх бүрэн боломжтой өвчин аж. Гэвч сэтгэл зүйн болоод эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж муу байгаагаас сэтгэл гутралд нэрвэгдэгсдийн бараг тэн хагас нь өвчнөө даван туулж чаддаггүй байгааг илтгэх судалгаа ч бий. Тийм ч учраас дэлхийн эрүүл мэндийн бодлого тодорхойлогчид нэн түрүүнд анхаарах учиртай өвчний тоонд оруулжээ.

гэж тооцоолсон ч хүнд учруулж буй хохирлыг нь тооцох боломжгүй байна. Учир нь, сэтгэл гутралд гүнзгий автсан хүн амиа егүүтгэдэг. Ийм шалтгаант амиа хорлолтын тоо жилд 850 мянгаар хэмжигддэг гээд бодоход анхаарлыг гадна үлдээж үл болох сэдэв юм.

ДЭМБ-ын мэдээгээр Монгол Улс зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн байдлын тархалтаар Ази, Номхон далайн баруун бүсийн 15 орноос долдугаарт ордог байна. Насанд

хүрэгчдийн хувьд хөдөлмөрийн чадвараа алдсан нь уг өвчнөөр шаналах гол шалтгааны нэг болдог бөгөөд цаашид ч өсөх төлөвтэй. 2013 онд манай улсын үндэсний хэмжээний судалгаагаар нийт насанд хүрэгчдийн 6.6 хувь нь сэтгэл гутрах эмгэгтэй байжээ.

#### СЭТГЭЛ ГУТРАЛ ӨСВӨР НАСНААС ЭХЭЛДЭГ

Сэтгэл гутралд автсаныг илтгэх анхны шинж тэмдэг ихэнхдээ өсвөр насанд илэрдэг

талаар НЭМҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан С.Гэрэлмаа хэллээ. Дэлхий дахинд 15-29 насныхны амиа хорлох шалгааны хоёрдугаарт сэтгэл гутрал бичигддэг гэх тоо бий. Манай улсын хувьд ч 10-19 насны хүүхдүүдийн амиа хорлох хоёр дахь шалтгаан болж буйг олон жилийн судалгаа харуулжээ. 1991-2014 онд нийт 443 хүүхэд амиа егүүтгэсэн бол, 2014 оноос хойш нийт 99 хүүхэд амиа хорлоод байна.

Өсвөр насныхны сэтгэл гут-

рал газар авч буйг илтгэх тоо баримт үүгээр дуусахгүй. 2013 онд Дэлхий дахины сургуульд суурилсан эрүүл мэндийн судалгааг Улаанбаатар хотын 5300 гаруй сурагчийн дунд явуулахад бас ноцтой тоо баримт илэрчээ. Судалгаагаар дөрвөн сурагч тутмын нэг нь амиа хорлох талаар бодсон, долоон сурагчийн нэг нь энэ аюулт үйлдлийг төлөвлөсөн гэж хариулжээ. Гэтэл нийт сурагчийн 10 гаруй хувь нь амиа хорлохоор нэг ба түүнээс дээш удаа завдсан нь өсвөр үеийнхний сэтгэл гутралыг зогсоох, эмнэхэд бодлого тодорхойлогчид нэн даруй анхаарал хандуулах учиртайг илтгэж байна. Мэргэжилтнүүдийн хэлж буйгаар хамгийн гол нь нийгэмд сэтгэл гутралтай иргэд олшрохын үндэс өсвөр наснаас эхэлж, нийгмийн хөгжилд сөрөг үр дагавар дагуулдаг аж.

Тиймээс дэлхийн улс орнууд сэтгэл гутралаас ангижрахад онцгойлон анхаарч, нийт зардлынхаа 1-3 хувийг зарцуулдаг бөгөөд цаашид нэмэх шаардлагатай гэж үзэж байна. Харин манай улсын хувьд энэ асуудалд энэ жилээс анхаарч, төлөвлөгөө гаргахаар ажиллаж буйгаа С.Гэрэлмаа ярилаа. [ЗГМ]

## ЗӨВЛӨГӨӨ СЭТГЭЛ ГУТРАЛЫГ ЭМЧИЛЖ БОЛДОГ

*Сэтгэл гутралд орсон нэгэнд бусдын тусламж нэн чухал байдаг аж. Бас ойр дотныхон нь сэтгэлд гутралд орсон байх нь хамт байсаа хүндээ ч амаргүй. Тиймээс энэ хүнд үеийг хэрхэн даван туулах талаар мэргэжилтнүүд дараах зөвлөгөөг өгдөг байна.*

#### Та үүнийг мэдэх үү?

- Сэтгэл гутрал бол зан чанарын доголдол, сул доройн шинж биш. Харин өвчин.
- Үүнийг эмчилж болдог. Гэхдээ өвчинд хэр гүн нэрвэгдсэнээс эмчилжээ, үргэлжлэх хугацаа хамаардаг.
- Найз нөхөд, гэр бүлийн дэмжлэг сэтгэл гутралаас гарах үр дүнтэй арга. Гэхдээ цаг хугацаа хэрэгтэй тул тэвчээр, шантрашгүй хүчин зүтгэл шаарддаг.
- Сэтгэл гутралд нэрмээс болдог гол зүйл бухимдал гэдгийг санаарай.

#### Сэтгэл гутралд автсан хүнийг тооно уу хийх вэ?

- Туслахыг хүсэж буйгаа ойлгуулж, шүүмжлэхгүйгээр сонсох хэрэгтэй. Дараа нь ямар нэг тусламж, дэмжлэг санал болгоорой.
- Сэтгэл гутрал ямар аюултай өвчин болохыг сайтар ойлго.
- Мэргэжлийн тусалцаа хэрэгтэй гэдгийг цагийг нь олж ойлгуул. Мөн хүсвэл мэргэжлийн эмчид хамт очих хэрэгтэй.
- Эмчилгээ шаардлагатай бол тэр тухай ойлгуулаарай. Хамгийн гол нь тэвчээртэй байгаарай. Нөхцөл байдал дээрлэл хэдэн долоо хононо.
- Өдөр тутмын амьдралд нь хань болж, хоол болон нойрны зөв хэмнэлд ороход нь туслаарай.
- Мөн дасгал хөдөлгөөн хийж, ойр орчинтойгоо харьцах боломжийг бүү алдаарай.
- Аливааг сөрөг биш эерэг байдлаар хүлээж авахад нь дэмжээрэй.
- Сэтгэл гутралд орсон хүмүүс өөрийгөө үгүйсгэх, амь насаа аюулд оруулах талаар бодож, магадгүй эл бодлоо гүйцэлдүүлэхээр хэдийнэ санаархсан бол ганцааранг нь хэзээ ч бүү орхи. Яаралтай болон мэргэжлийн тусламж эргэлзэлгүй ав. Мөн эм, хурц үзүүртэй болон ирмэгтэй зүйлс, зэвсгийг холдуулаарай.
- Өөртөө ч мөн анхаарал тавь. Амрах боломж бүрийг ашигла. Сэтгэлд гутралд орсон хүнд таны уйгагүй дэмжлэг хэрэгтэй шүү дээ. Тиймээс хүч чадлаа сэлбэх хэрэгтэй.
- Хамгийн гол нь сэтгэл гутрал эмчлэгддэг. Анхаарал, дэмжлэгээ эмчийн тусламжтай хослуулах нь үр дүнтэй. [ЗГМ]

**Олон Улсын Сэтгүүлчдийн Холбоо**  
**Монголын асуудлаар мэдэгдэл түгээлээ**

Дэлхийн 140 орон гишүүнээр нь элссэн Олон Улсын Сэтгүүлчдийн Холбоо (IFJ) Монголын тухай албан ёсны мэдэгдлийг дэлхий даяар түгээлээ. ОУСХ нь өөрийн гишүүн орнуудад хийгдэж байгаа хэвлэл мэдээллийн эрх чөлөөний үзэл санаатай холбоотой сайн, саар жишээнүүдийг мэдээлэн түгээдэг уламжлалтай бөгөөд энэ удаад Олон улсын "Хууль ба Ардчилал" төвийн дүгнэлтийг үндэслэн Монголтой холбоотой мэдэгдэл түгээсэн байна. Уг мэдэгдэлд "Монгол Улсын засгийн газраас Парламентдаа өргөн барьж буй Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн төслийг Олон Улсын Сэтгүүлчдийн Холбоо нь өөрийн гишүүн байгууллага болох Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлтэй хамтран хүлээн авч байна. Олон улсын сэтгүүлчдийн холбооны зүгээс Монгол Улсын засгийн газрыг энэхүү хууль болон хуулийн хэрэгжилтийн талаар сонирхогч талуудыг оролцуулан нухацтай хэлэлцүүлэхийг уриалж байна.

Сүүлийн хэдэн жилийн турш маргаан дагуулж, олон янзын хувилбар дэвшүүлж байсан "Өргөн нэвтрүүлгийн тухай хууль"-ийн төсөл Монголын парламентаар гуравдугаар сарын эхээр хэлэлцэгдэх гэж байна. Сүүлийн жилүүдэд Монголын хэвлэл мэдээллийн байгууллагуудын тоо мэдэгдэхүйц өсч гурван сая хүн амтай улсад 400 хэвлэл мэдээллийн байгууллага үйл ажиллагаа явуулах болсон. Хууль нь хэвлэл мэдээллийг зохицуулахад хэрэгтэй ч, агуулга нь хэвлэл мэдээллийн нөлөөлөл болон хүч боломжийг хязгаарлахад энэ хуулийн төсөл чиглэгдсэн байна.

Хууль ба Ардчилал Төвөөс энэ хуулийн төсөлд дүн шинжилгээ хийсэн бөгөөд Хууль ба Ардчилал Төвийн Гүйцэтгэх Захирал Тоби Мендэл хэлэхдээ: "Өргөн нэвтрүүлгийн тухай хууль нь хэрэгцээ шаардлагад чиглэгдээгүй байгаад миний урам хугарлаа. Энэ хууль нь бие даасан үйл ажиллагааны зохицуулалтыг бүрэн хаасан бөгөөд нийгэмд зориулсан өргөн нэвтрүүлгийн талаар нэг ч дурьдаагүй байна" гэлээ.

Монголд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд улс төр хөндлөнгөөс оролцох нь сүүлийн жилүүдэд ихсэж байгаа нь баримтаар нотлогдоод байна. Хэвлэлийнхэн тодорхой сэдвээр гүнзгийрсэн нэвтрүүлэг хийвэл улс төрчдийн зүгээс тусгай зөвшөөрлийг нь хураах, үйл ажиллагааг нь хахаар заналхийлж байна. Гэтэл хуулийн төсөлд энэ талаар тусгааргүй бөгөөд улс төрийн тоглогчоос лиценз, зөвшөөрөл хамаарах ёсгүй гэдгийг Хууль ба Ардчилал Төвөөс онцгойлон тэмдэглэж байна.


Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл энэ асуудлаар бас албан ёсны байр сууриа илэрхийлж байгаа бөгөөд МСНЭ-ийн Ерөнхийлөгч Б. Галаарид хэлэхдээ: Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл нь Олон Улсын Сэтгүүлчдийн Холбоо болон Хууль ба Ардчилал Төвөөс Монголын "Өргөн нэвтрүүлгийн хууль"-ийн төслийн талаар гаргасан дүгнэлттэй санал нэгдэж байна.

Монголын төр хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн үйл ажиллагаатай холбоотой аливаа хууль тогтоомж гаргахдаа Монголын сэтгүүлчдийн мэргэжлийн шүхэр байгууллага болох Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл болон сэтгүүл зүйн чиглэлээр мэргэшсэн бусад ТББ-уудаас зөвлөмж, санал авч, төсөл боловсруулах ажлын хэсэгт төлөөлөл оролцуулдаг байсан уламжлалаасаа сүүлийн үед татгалзаж эхлээд байгаад харамсаж байна" гэлээ.

Олон Улсын Сэтгүүлчдийн Холбоо (IFJ) энэ асуудлаар албан ёсны байр сууриа илэрхийлэхдээ: "Бид Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлтэй нэгдмэл байр суурьтай байгаа бөгөөд засгийн газрын зүгээс аливаа хуулийн төсөл гаргахаасаа өмнө бүх талыг хамруулсан зөвлөгөөн, хэлэлцүүлэг хийх ёстой. Хэвлэл мэдээллийн салбарт мэргэжил мэдлэгээрээ арвин баялаг, сэтгүүлч мэргэжлийн талаар чухал зөвлөмж, зөвлөгөө өгөх хувьцаа эзэмшигчид болон Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлийг төсөл боловсруулах үйл явцад Засгийн газрын зүгээс итгэл хүлээлгэн оролцуулах хэрэгтэй" гэсэн байна.

**Мэдээллийн дэлгэрэнгүйг: Олон Улсын Сэтгүүлчдийн Холбоо (ОУСХ),**  
**Ази Номхон Далайн Бүс нутаг: Утас: 61 2 9333 0946**  
**Олон Улсын Сэтгүүлчдийн Холбоо нь 140 орны 600.000 гаруй**  
**сэтгүүлчдийг төлөөлдөг**  
**ОУСХ-ны твиттер хаяг: @ifjasiapacific**  
**ОУСХ-ны фэйсбүүк хаяг: www.facebook.com/IFJAsiaPacific**

### ЗГМ: ИНФОГРАФИК



# Лавлах

## ХУРАЛ Дэлхийн Үйлдвэрлэгчид Монголд

Г.Төгс  
ЗГМ

Дэлхийн шилдэг технологи үйлдвэрлэгч, хөрөнгө оруулагчдын “Технологи, хөрөнгө оруулалт Монголд-2017” олон улсын үзэсгэлэн, чуулга уулзалт энэ сарын 20, 21-нд Улаанбаатар хотын Шангри-Ла зочид буудалд болох гэж байна. Энэхүү олон улсын үзэсгэлэн, чуулга уулзалтыг “Би Эм Монголиан Партнерс” компанийн санаачилгаар зохион байгуулж байгаа аж. Үзэсгэлэнгийн үеэр дэлхийн дэвшилтэт технологи, шилдэг тоног төхөөрөмжийг танилцуулах бөгөөд гадаадын хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах боломжтой хэмээн зохион байгуулагчид хэллээ. Одоогийн байдлаар тус арга хэмжээнд Австри, Швейцарь, ХБНГУ зэрэг дэлхийн 20 гаруй орны компани оролцохоор бүртгүүлжээ. [ЗГМ]

## ҮЗЭСГЭЛЭН Ховор цэцэгсийг тольдоорой

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв дээр өнөөдөр тасалгааны цэцгийн үзэсгэлэн худалдаа нээгдэж байна. Үзэсгэлэнг “Монголын байгаль эхийн аврал” ТББ болон Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв хамтран зохион байгуулж байгаа аж. Тус үзэсгэлэнд хүрэлцэн ирснээр нөмөргөнө, нил ягаан, хойя зэрэг ховор нандин цэцэгсээс гадна маш олон төрлийн цэцэг, үр, үрсэлгээ, бордоо, техник хэрэгслүүдийг сонирхох боломжтой. Мөн энэхүү үзэсгэлэн нь энэ сарын 9-нийг хүртэл үргэлжлэх ба та бүхэнд зориулан цэцэг хэрхэн тарьж ургуулах, үржүүлэх талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх аж. [ЗГМ]

## ТЕХНОЛОГИ “Ногун” шинэ бэлгээ задаллаа

Хүүхэд багачуудын унших дуртай, байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах арга ухааныг зааж, сургахад хувь нэмрээ оруулж буй “Ногун” комик шинэ хэсэг хүргэж байна. Комикийг бүтээгчид энэ удаа бүх насныханд зориулсан цахим эвлүүлдэг тоглоом бүтээжээ. Энэхүү тоглоомондоо “Ногун” комикийн гол дүүрийн баатруудын зургийг эвлүүлэх бөгөөд нийт 10 үетэй аж. “Ногун” цувралын ээлжит бэлгэ эвлүүлдэг тоглоомыг та ухаалаг утас, таблетандаа татах боломжтой. “Nogun Puzzle” аппликейшнийг үнэ төлбөргүйгээр татан суулгаарай. [ЗГМ]

## УЛААНБААТАР Мянган оюутныг цэрэгт татна

Өнгөрсөн хугацаанд “Оюутан цэрэг” хөтөлбөрт 2390 оюутан хамрагдсан бол энэ жил мянган оюутныг хамруулахаар Батлан хамгаалахын сайдын тушаал гарчээ. Тус хөтөлбөр нь өнгөрсөн хугацаанд амжилттай хэрэгжсэн бөгөөд цэргийн насны залуус иргэний цэргийн үүргээ биелүүлэх нөхцөлөөр хангаж, дайчилгааны бэлтгэл, нөөцийн бүрэлдэхүүн нэмэгдэх зэрэг олон талын ач холбогдолтой байв. Мөн оюутан залуусыг эх орноо батлан хамгаалах, эрүүл чийрэг, бие бялдартай, сэтгэл зүйн бэлтгэлтэй хувь хүн болгон төлөвшүүлдэг байна. [ЗГМ]

### ТВ ХӨТӨЛБӨР

	MNB	Bloomberg	Боловсрол	Монгол ТВ
08.00	09.00 “Дөлгөөн Дон” Оросын уран сайхны кино	08.00 “Bloomberg Daybreak Asia”	09.45 “Би Монгол хүн” нэвтрүүлэг	10.00 “Дөрвийн эсрэг дөрөв” нэвтрүүлэг
12.00	11.00 “Монголын мэдээ” мэдээллийн хөтөлбөр	11.30 “Шилдэг санаа” нэвтрүүлэг	12.10 “Гайхалтай аялал” нэвтрүүлэг	12.30 “Сонсье, сурья, дагая” хүүхдийн нэвтрүүлэг
14.00	14.00 “Монгол өв соёл” хөтөлбөр	15.00 “Бизнесийн төв цэг” хөтөлбөр	14.10 “Ялалт” ток шоу нэвтрүүлэг	14.00 “Спортын шинжлэх ухаан” нэвтрүүлэг
18.00	18.15 “Би би” бага насныханд зориулав	17.00 “Bloomberg Surveillance”	18.35 “Дэлхийн атлас” танин мэдэхүйн нэвтрүүлэг	19.00 “Часс...” COOK SHOW
20.00	21.05 “Баасан гараг” цэнгээнт нэвтрүүлэг /шууд/	20.00 “Блумбергийн ярилцах цаг” нэвтрүүлэг	20.40 “Аугаа уран зургууд” нэвтрүүлэг	21.00 “Оёдлын газрын боловсон эрчүүд” СОАК
22.00	22.55 МҮОНТ-ийн алтан сан хөмрөгөөс. Миний ард түмэн “Үзэмчин ясны тухай”	22.30 “Шилдэг санаа” нэвтрүүлэг	00.00 “Кино миний амьдрал” нэвтрүүлэг	00.00 “Орголт” ОАК

### ОНЦЛОХ ҮЗВЭР

## Залуу хосын дурлалын түүх



Францын зохиолч Анри Мургерийн “Богемын гудамжин дахь үзэгдлүүд” зохиолоос сэдэвлэн Луизи Иллика, Жузеппе Жакоза нар бичсэн “Богема” дуурийг Г.Эрдэнэбаатарын найруулгаар энэ сарын 30-ны 17.00 цагт ДБЭТ-ын тайзнаа толилуулаа. Үлгэрийн мөртлөө бодит мэт уран дүрслэлийг өгүүлэх дуурийн зохиолыг Ж.Пуччини 1895 онд бичжээ. Дуурьд залуу эр, залуу бүсгүй хоёр танилцан дурлалцаад, амьдралын эрхээр түр салж байснаа үүрд хагацахын тулд ахин уулзаж буйг өгүүлнэ. “Богема” дуурийг 1896 оны хоёрдугаар сарын 1-нд Турин хотын “Ла Режио” театрт анх тогложээ. Ингэснээр Италийн дуурийн театруудын урын санд орж, тун удалгүй дэлхийн театруудын хамгийн их тоглодог бүтээл болж чаджээ. [ЗГМ]

### ҮЗВЭР

#### УДБЭТ

Их зохиолч Д.Нацагдоржийн зохиолоос сэдэвлэн бүтээсэн “Ламбугайн нулимс” дуурийг энэ сарын 9-нд 17.00 цагт тоглоно.

#### УЛСЫН ФИЛАРМОНИ

“Баянмонгол” хамтлаг дэлхийн алдартай хүүхэдэйн кинонуудын хөгжмөөс толилуулах гэж байна. “Танил ертөнц” багачуудад зориулсан энэхүү тоглолт өнөөдөр 15.00 цагт болно.

#### BLUE MOON ГАЛЕРЕЙ

Уран зураачдын нэгдсэн “Хаврын мэдээ” үзэсгэлэн энэ сарын 9-н хүртэл үргэлжилнэ.

#### IMAX

“Baby boss” бяцхан хүүд тохиолдох инээдмийн хүүхэдэйн кино өнөөдөр нээлтээ хийнэ.

#### УЛААНБААТАР ЧУУЛГА

Үндэсний болон цахилгаан хөгжмийг хослуулсан “World music” чуулгын уран бүтээлчдийн нэгдсэн концерт өнөөдөр 19.00 цагт болно.

#### “АЗ ХҮР”

Хүүхэд, багачуудад зориулсан “Үлгэрийн цаг” хөтөлбөр ням гараг бүрийн 13.00 цагт болно. Энд хүрэлцэн ирснээр монгол ардын болон дэлхийн сонгодог үлгэрүүдийг үнэ төлбөргүйгээр хүүхдэдээ сонсох боломжтой.

#### УДЭТ

“Сонгодог жүжгийн өдрүүд” хөтөлбөрийн хүрээнд Уильям Шекспирийн “Гамлет” жүжгийг энэ сарын 9-нд тоглоно. Тасалбарын үнэ 10-30 мянган төгрөг.

#### UB PALACE

Дуучин П.Хэрлэнгийн “Анд минь чамайг үгүйлнэ” тоглолт өнөөдөр 19.00 цагт болно. Тэрбээр олны сэтгэлд хоногшсон “Үнэнч хайр”, “Дорнын уудам хязгаар” бүтээлүүдээ энэ үдэш толилуулах юм.

#### VEGAS CLUB

“White wonderland” үдэшлэг өнөөдөр, маргааш хоёр өдөр болно. Үдэшлэгт реппер Рокит Бэй, Б.Номин, Цэцэнбилэг болон “Бэртэ чонын үрс”, “Улаан туг” бүжгийн хамтлаг зэрэг залуу уран бүтээлчид оролцоно.

### ЗУРХАЙ



#### Билгийн тооллын 11

Хаврын дунд харачиган туулай сарын дөрвөн ногоон мэнгэтэй хөх хулгана өдөр. **Үс засуулбал:** Эрхтэн хурц болно. **Наран ургах, шингэх:** 06.20-19.29 **Барилдлага:** Түлэх **Шүтэн барилдлага:** Өтлөх үхэхүй

#### Ардын тооллын дөрөвдүгээр сарын 7, Сугар гараг. Билгийн тооллын 11, Их морь одтой, хөх хулгана өдөр.

Өдрийн наран 06.20 цагт мандан, 19.29 цагт жаргана. Тухайн өдөр луу, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр гэмтнийг шийтгэх, лусыг тахиж, хүүхэд үрчлэн авах, хур оруулах, дарханы үйлд сайн. Улааны үйл, төлөг тавих, морь уралдах, сэтгэлд сэвтэй газар очиход муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Тэрсүүд өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эрхтэн хурц болно.


#### ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-Москва	13.50	14.28
Москва-УБ	21.35	07.30
Эрэн-УБ	18.00	11.15
Хөх хот-УБ	22.50	11.15
УБ-Хөх хот	20.00	20.49
Эрхүү-УБ	15.35	06.20
УБ-Эрхүү	21.10	02.40

#### НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-Хонгконг	06.20	10.50
УБ-Ханбумбат	13.50	15.00
УБ-Сөүл	08.45	12.50
Хонгконг-УБ	12.00	16.40
Сөүл-УБ	14.20	16.50
УБ-Бээжин	17.55	20.10
Бээжин-УБ	21.10	23.40

### ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



- ..... ноолуур
- ..... авай
- ..... даам
- ..... шир
- ..... харх

- ..... хоморго
- ..... газар
- ..... ирмэг
- ..... сум
- ..... болор

Өмнөх дугаарын хариу / 04.07



### БОСООГООР:

- Хурал .....
- ..... зэтгэр
- ..... зочлолмтой
- ..... жил

### 5. Шавь .....

- ..... дарцаг

### ХӨНДЛӨНГӨӨР:

- ..... буга

### ЦАГ АГААР

#### УЛААНБААТАР



Үүлшинэ



Багавтар үүлтэй




Багавтар үүлтэй



Үүлшинэ



Бага зэргийн хур тунадастай



### ЗГМ: КОМИКС



**[ЗГМ]**

“ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ”  
СОНИНЫ ОНЛАЙН ЗАХИАЛГА  
ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА.

“ZGM-FINANCIAL TIMES-NYT”  
ДЭЛХИЙН ХЭВЛЭЛИЙГ НЭГ ДОРООС  
ЗАХИАЛГЫН ҮНЭ УЛИРАЛД  
5000 ТӨГРӨГ

99903581, 70103131

УНШИГЧ ТА МАНАЙ  
СОНИНЫ НИЙТЛЭЛ, МЭДЭЭ,  
СУРВАЛЖЛАГАТАЙ  
ХОЛБООТОЙ САНАЛ  
ХҮСЭЛТЭЭ

OPED@ZASAG.CO

ХАЯГААР ИРҮҮЛНЭ ҮҮ.





## Цахим эрсдэл назгайрлаас үүдэлтэй

Британийн албан хаагчид өөрийн мэдээлэл болон техник хэрэгслээ хамгаалж чаддаггүй аж. > 10

## Кремлиэс жагсаал зохион байгуулсан гэв

Эрх баригчид одоо терроризмын эсрэг жагсаалд олныг дайчилж байна. > 10

## Хөгжмийн зах зээл сэргэсэн жим

2016 онд 3.9 тэрбум ам.доллараар өсөж нийт 7.7 тэрбумаар хэмжигдлээ. > 10



BBM©

# Клинтоныхны нэр хүнд сэргэшгүй сэвтжээ

Эдвард Льюс

Клинтоныхон сонгуулиас хойш удаж төдөлгүй олны анхаарлыг татаж эхэллээ. Дональд Трампд ялагдаад таван сарыг үдсэн хатагтай Хиллари Клинтон тайз руу гэтэж буй боллоотой. Тэрбээр Цагаан ордны төлөө дахин өрсөлдөхгүй гэж мэдэгдсэн. Үгүйсгэлгүйгээр үгүйсгэхийн урлагийг сайтар эзэмшсэн охин Челсигээс нь Ерөнхийлөгчийн суудлын талаар асуухад тийшээ зүглэхгүй гэж байгаа. Олон нийтийн өмнө гарах тухай яриа хөөрөө алга. Клинтоныхон өөрсдөө ч ийн хэлж буй. Тэд хүсэл зоригоосоо татгалзсан гэх боловч нийтийн өмнө хариуцлага хүлээх албанд дургүйхэн буцан ирж магадгүй юм.

Ийм байдал ноён Трампд таатай боломж бүрдүүлнэ. Юуны өмнө энэ нь Ардчилсан намынхны зүгээс Ерөнхийлөгч рүү хийх дайралтыг сулруулах учиртай. Асар их зөрчлийн дундад Трампын захиргааны нэг онцлог бол түүний удирдлага гэр бүлийн бизнес болон хувирч байгаа явдал. Трампын хүргэн Жаред Кушнер Цагаан ордны хамгийн чухал хүн болжээ. Ерөнхийлөгчийн охин Иванка Цагаан ордны баруун жигүүрт сууж байгаа. Ноён Трампын бизнес, эрх ашгийг албан тушаалаас нь зааглаж буй хана үл үзэгдэнэ. Түүний хоёр хүү

Эрик болон бага Дональд нар Трампын бизнесийг зохицуулж буй гэх авч Цагаан ордноор орж, гарах нь олонтаа.

Трампынхантай жишиж болохуйц цорын ганц гэр бүл бол Клинтоныхон. Иванка, Челси хоёр найзууд. Хэрэв хатагтай Клинтон сонгуульд ялсан бол Челсиг Иванкагийн оронд байгаагаар төсөөлөхөд түвэггүй. Хоёрдугаарт, Клинтоныхон Сьюзан Сарандоныг хүртэл арваннэгдүгээр сард яагаад ялагдсаныг сануулах болно. Хилларийг дэмжигчид үүнд Владимир Путин, Берни Сандерс, New York Times сонин, чиг зүггүй сонгогчид, сонгогчдын зөвлөлөөс авахуулаад жүжигчин талаар мөрдөн байцаалтыг буруутгадаг. Хэтрүүлэн хэлбэл хатагтай Клинтонноос бусад нь бүгд буруутай гэсэн үг.

Нөгөө талаар Хиллари хүмүүс өөрөөс нь урвасан гэх сэтгэлд автсан гэж ярилцдаг. Энэ нь түүний нийгмийн үйл хэрэгт дахин хөл тавих нэг шалтгаан байж болох. Америкийг Трампд алдсан хүн гэдэг нэр зүүж явах нь түүний хувьд ахадсан ачаа байж магадгүй. Түүний зовнилыг ойлгож болно. Сэтгэлээ эмчлэх ганц арга бол ямар нэг зүйлийн төлөө тэмцээд ялах явдал. Гэхдээ л Трампын ялалт бол түүний ялагдал. Тэрбээр Ерөнхийлөгч болоод юу бүтээхээ сонгогчдод хүргэж чадаагүй.

Гурав дахь хүчин зүйл бол Клинтон олны өмнө ил гарах нь Трампын ашиг сонирхолд нийцнэ гэсэн үзэл санаа. Трамп хуучин өрсөлдөгч рүүгээ дайралгүй ганц долоо хонож байна. Тэрбээр хатагтай Клинтон Ардчилсан нам доторх халз мэтгэлцэнээс өмнө асуултыг урьдаас мэдэж байсан тухай твиттертээ бичжээ. АНУ-ын Ерөнхийлөгч болсон хүн одоог эрхэж ирвэл Ардчилсан нам арваннэгдүгээр сард яагаад ялагдсаныг сануулах болно. Гэвч энэ нь Трампын болчимгүй арга барил юм. Тэр Хилларийн тухай сануулсаар байх юм бол усыг улам л булингартуулна.

Америкуудын олонх нь АНУ-ын сонгуульд Оросын оролцооны талаар мөрдөн байцаалтыг сонирхохоо больсон. Клинтон улс төрийн тавцанд буцаж ирвэл Трампын хувьд Оросын дуулиан шуугианыг намжаахад дөхөмтэй. Клинтоныхонд үл итгэх үзэл Трампд үл итгэхтэй бараг адил өргөн тархаад байгаа билээ. Ийм байдал Америкийн ардчилалд хөнөөлтэй юм. Өнгөрсөн оны сонгууль Клинтон болон Бушийнхны хоорондын өрсөлдөөн болно гэсэн хүлээлттэй байсан нь одоо бараг мартагджээ. Харин Трампын гэр бүл ялагчаар тодорсон. Энэ нь өрнөдийн ардчиллын нэр хүндэд хэдий чинээ хохирол учруулсныг үнэлж цэгнэхэд бэрх. Гуравдагч ертөнцийн гэх

орнуудын дипломатууд Трампын Вашингтон тэдэнд маш танил санагдаж байгаагаар надад олонтаа ярьсан.

Ерөнхийлөгчийн хамаатан саданд ойр байх нь шийдвэрлэх ач холбогдолтой. Меритократын үнэр ч алга. Танил тал татах явдал хэрээс хэтэрлээ. Клинтоныхон үүнийг цэвэрлэж чадна гэдэгт хүмүүс найдаж байгаа болов уу. Асуулт өөртөө хариултыг агуулсан байна. Хатагтай Клинтоньг Нью-Йорк мужийн захирагч, эсвэл хотын дарга хэмээх том албан тушаалд өрсөлдөх санал ирсэн аж. Түүний охиныг ирэх онд конгресст, эсвэл 2020 онд сенатад нэрээ дэвшүүл хэмээн ятгаж буй гэсэн.

Ийм нэр дэвшигчид гадаад орчинд хэрхэн нөлөөлөхийг тойрон хүрээлэгчид нь ойлгож байгаа болов уу. Клинтоныхныг шүтэн бишрэгчид тэднийг улс төрд эргэж орвол ашиг хонжоо олно хэмээн найдаж буй. Гэвч энэ нэр олны зөвүүцлийг төрүүлж болзошгүй юм. Америкийн иргэдийн хувьд Клинтоныхон элит ангийн төлөөлөл. Иймээс тэдний хувьд Трампд өгөх хамгийн хүчтэй цохилт бол улс төрийн амьдралыг орхих явдал. Клинтоныхон өөрийн ээлжээ гүйцэтгэсэн. Тэд ирээдүйн удирдагчдын нарыг халхлах ёсгүй.



# Бүтээмж хямралын өмнөхөөс доошлов

Крис Жайлз

Сүүлийн судалгаанаас үзэхэд бизнесүүд хямралын өмнөх үр ашигт хүрч амжаагүй байгаа аж. Өнгөрсөн оны дөрөвдүгээр улиралд нэг цагийн бүтээгдэхүүний гаргалт 0.4 хувь өссөн нь түүрүү ноньхоос 1.2 хувиар дээшилсэн тоо юм. Гэвч бүтээмжийн энэхүү үзүүлэлт 2007 оныхоос нэлээд доогуур хэвээр байна. Нэг цагийн гаргалт өсөхгүйгээр эдийн засаг өргөжихөд хүндрэлтэй бөгөөд эдийн засгийн өсөлт илүү цагийн ажил буюу олон хүн ажилласнаар бүрдэх болно. Гэвч ажил эрхлэлт дээшилсэн үед ийм нөхцөлийг бүрдүүлэхэд бэрхшээлтэй.

2009 оноос хойших сэргэлтийн үед бүтээмжийн өсөлт бараг ажиглагдсангүй. Тухайлбал нэг цаг ажилласан бүтээгдэхүүн гаргалт болон нэг ажлын байрны гаргалт 2007 оны оргил үеийнхээс үл ялиг давжээ. АНУ, Япон, Европын эдийн засгуудад бүтээмж буурсаны зэрэгцээ Их долоогийн орнуудаас Британид хамгийн ихээр багасчээ. Үндэсний статистикийн оффисын шинжээч Филип Уэльс “Саяхан үйлдвэрлэл ба үйлчилгээний салбаруудад бүтээмж дээшилсэн нааштай үзүүлэлт боловч хямдралын өмнөх түвшинд хүрэхгүй шахуу байна” гэв.

холбоо, нийтийн үйлчилгээ, зөвлөх, хууль болон нябарт бүртгэлийн үйлчилгээний салбар голдуу ажиглагдсан байна. Эдгээр салбар эдийн засгийн 11 хувийг бүрдүүлдэг авч сааралтын гуравны нэгийг эзэлжээ.

Британийн бусад оронтой харьцуулсан бүтээмжийн ялгаа урьдын адил нэлээд өндөр хэвээр байна. 2015 оны баримтаас харвал Британийн ажилчны нэг цагийн гаргалт Их 7-гийн орнуудын дунджаас 16 хувь доогуур байгаа аж. Франц, АНУ, Германы нэг ажилчин дөрөв хоногт Британийн ажилчны таван өдөр гаргасан бүтээгдэхүүнээс илүүг үйлдвэрлэдэг. Британийн дундаж ажилчин цагт Японы ажилчнаас илүүг бүтээдэг бол Канадынхтай бараг ижил, Италийнхаас 10 хувь, АНУ, Францынхаас 30 шахам хувь, Германынхаас 30 гаруй хувь доогуур бүтээмжтэй байна.

АНУ-ын ажилчид хамгийн өндөр бүтээмжтэй боловч Европын олонх орноос илүү цагаар ажилладаг тул нэг цагийн бүтээмж нь Герман, Францынхаас доогуур байдаг. Британийн бүтээмжийн өсөлт удааширсныг харуулах өөр нэг үзүүлэлтийг ажилчны үр ашгийг дээшлүүлэхэд шаардлагатай капиталын хэмжээнээс харж



BBM©

Хямралын дараа үйлдвэрлэл, үйлчилгээний аль алинд бүтээмж унасан боловч аж үйлдвэр эхлээд түргэн сэргэсэн. 2013 оноос хойш үйлчилгээний салбарын бүтээмжийн өсөлт үйлдвэрлэлийнхтэй тэнцэж иржээ. Манай сонин судалгаагаар нийт хугацаанд бүтээмжийн өсөлтийн сааралт банк, теле

болно. 2012 оноос хойш өсөлт капиталас илүүтэй илүү тооны хүмүүсийг ажиллуулснаар хангагдсан байна. Үндэсний статистикийн оффис 1997 оноос хойш Британид бүтээмжийн өсөлтөө зарцуулсан капитал багассаар ирснийг “гайхалтай” хэмээн нэрлэжээ.



# Трамп, Ши нарыг дарамтлах Пхеньяны оролдлого

Деметри Севастополо

АНУ ба Хятадын Ерөнхийлөгч Дональд Трамп, Ши Жиньпин нар Хойд Солонгосоос Япон тэнгис рүү пуужин харвасны дараахан уулзаж байна. Хоёр их гүрний төрийн тэргүүнүүдийн уулзалт хэлэлцээний явцад нэг гол сэдэв нь Хойд Солонгосын асуудал болж байгаа юм. АНУ-ын Батлан хамгаалахын яам лхагва гарагт харвасан пуужин есөн минутын дараа тэнгист унасныг нотоллоо. Тус яамны мэдээнд пуужин дундын тусгалтай бөгөөд АНУ-ын нутаг дэвсгэрт хүрэх боломжтойг онцлоод Синпо хэмээх газарт байрлалтай цэгээс хөөрснийг дурджээ. Өмнөд Солонгосын тал уг пуужин KN-15 төрлийн баллистик пуужин байх боломжтой ба 60 км нисээд тэнгист унасныг мэдээлэв.

Ерөнхийлөгч Трамп Хятадын удирдагчийг Флорида муж улс дахь Мар-а-Лога хэмээх амралт сувиллын газарт хүлээн авч байгаа. АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Рекс Тиллерсон хэлэхдээ “Хойд Солонгос дундын зайн тусгалтай бас нэг баллистик пуужин нисгэлээ. АНУ Хойд Солонгосын талаар хангалттай ярьсан. Бидэнд өөр тайлбар алга” хэмээн мэдэгдэв. Хятадын Гадаад хэргийн сайд Ван И “зогсоосны хариуд зогсоох” буюу Пхеньян цөмийн болон пуужингийн туршилтаа зогсоож, хариуд нь АНУ, Өмнөд Солонгос хоёр

цэргийн сургуулиалтаа зогсоохыг санал болгосон билээ. Гэвч Вашингтон, Сөүл хоёр уг саналыг няцаасан.

Түүнчлэн Японы Ерөнхий сайд Шинзо Абэ Хойд Солонгосын үйлдлийг эрс буруушаав. Тэрбээр “Энэ бол цаашдаа өдөөн хатгалт явуулахын тод илрэл. АНУ болон Өмнөд Солонгостой сайтар ярьж хэлэлцээний үндсэн дээр бид ямар ч нөхцөл байдал үүсэхэд иргэдийнхээ амь нас, өмч хөрөнгийг бүх талаар хамгаалах болно” гэжээ. Сөүл цаашдын ямар ч өдөөн хатгалтад хатуу хариу өгөхийг анхааруулаад пуужингийн туршилтыг НҮБ-ын тогтоолыг эсэргүүцсэн явдал хэмээв. Уг тогтоолоор Хойд Солонгосыг цөмийн ба пуужингийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахыг хориглосон



BBM©

байв.

Өнгөрсөн сард Хойд Солонгос Япон тэнгисийг чиглүүлэн дөрвөн баллистик пуужин харваснаас гурав нь Японы эргээс 300 км дотогш зайд унасан билээ. Гуравдугаар сард бас нэг пуужин хөөргөхийг оролдсон боловч амжилтгүй болсон. Шинжээчид Пхеньян Америкийн эх газарт цохилт өгөх чадвартай, цөмийн цэнэг тээх пуужингийн

технологи боловсруулж чадаагүй гэж үздэг. Гэхдээ Пентагон ийм чадамж бий гэсэн өгөгдөлд суурилан хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлдэг байна.

Ерөнхийлөгч Трамп Хятадын удирдагчид хандан Хойд Солонгосыг цөмийн хөтөлбөрөө зогсоохыг ятгахыг уриалах бодлоотой байгаа талаар Financial times сонин өмнө нь мэдээлсэн. Үүний зэрэгцээ ноён Трамп уг

асуудлаар Вашингтон дангаар арга хэмжээ авахад бэлэн байгааг анхааруулсан юм. Eurasia Group судалгааны төвийн захирал Эван Медейрос “Дээд удирдагч Ким Жон Ун дахиад л бусдын анхаарал татахаар орилж эхэллээ. Дээд хэмжээний уулзалтын өмнө ноён Трамп, Ши нарын аль алинд дарамт үзүүлэхийг оролдож байна” хэмээн өгүүллээ.



## Цахим эрсдэл назгайрлаас үүдэлтэй

### Ханна Кушлер

Дэлхий даяар компаниудын Удирдах зөвлөлийн хэлэлцэх асуудалд цахим аюулгүй байдал орж ирлээ. Захирлууд хакерын дайралтын хохирогч болохоос болгоомжилж эхэлжээ. Үүнд үйлчлүүлэгчдийн мэдээлэл, эсвэл өндөр өртөгтэй оюуны бүтээлээ алдах, бизнесийн үйл явц тасалдах зэрэг аюул багтана. Гэхдээ тэд цахим гэмт хэрэгтнүүд төдийгүй ажилтнуудынхаа назгайралтай тэмцэх ёстой. Ажилтнууд цахим аюулгүй байдалд өөрийн үүргийг ухамсарладаггүй буюу хойрго ханддаг тал бий.

Тухайлбал, Британийн албан хаагчид өөрийн мэдээлэл болон техник хэрэгслээ хамгаалж чаддаггүй аж. Өнгөрсөн онд 10 орныг хамруулсан Берклейн цахим хөгжлийн индексээс үзэхэд Британи улс Бразил, Хятад, Өмнөд Африкийн дараа есдүгээр байрт бичигджээ. Энд дурдсанаар цахим чадамжийн дутагдал Британийн бизнес болон хувь хүмүүсийг эрсдэлд оруулж байгаа гэнэ. Британичуудын 13 хувь нь түлхүүр үг ашигладаг бол энэ үзүүлэлт Хятад, Энэтхэгт 32 хувь байна. Түүнчлэн дөнгөж 41 хувь нь түлхүүр үгээ байнга сольдог ба төлбөрийн мэдээллээ олон ашигладаг вебсайтад үлдээдэг аж.

Glasswall Solutions компанийн

дэд захирал Крис Дай “Бүтээмж болон ая тухыг аюулгүй байдлаас дээгүүр тавьж байна. Хүмүүс байнга холбоотой байх ёстой гэж боддог учир компаниуд хэрэгслүүдээ

нээлтэй орхиж байна” гэж дүгнэжээ. FTSE-д бүртгэлтэй 100 компанийн 87 хувь нь цахим аюулгүй байдлыг гол аюул гэж үздэгийг тус компанийн судалгаа илрүүлсэн юм. Гэтэл

тэд ажилтнууддаа энэ бол амин чухал асуудал гэдгийг ойлгуулж чадаагүй байсан гэж мэргэжилтнүүд дүгнэв.

Фишинг буюу нэвэл вирустэй контент агуулсан мэйл илгээх

гэмт хэрэг нэмэгдэж байгаа нь ажилтнуудад нэмэлт мэдээлэл өгөх шаардлагатайг харуулж байна. Теле холбооны Verizon компани 2016 онд фишингийн 10,000 тохиолдлыг шалгаж

үзээд 1000 удаад нь мэдээлэл алдагдсаныг илрүүлжээ. Хүмүүс фишинг зорилгоор ирүүлсэн арван мэйлийн бараг гурвыг нь нээдэг ба 12 хувь нь цааш үзэх холбоосыг дардаг аж. Цагт хавчигддаг ажилтай хүмүүс, жишээ нь хуульч, сэтгүүлч, олон нийттэй харилцах албаныхан гаднаас олон мэйл авдаг тул хохирогч болох нь олонтой.

Ноён Дай цааш нь “Хүмүүс мэдэх, мэдэхгүй сурвалжаас ирж буй мэдээллийг хэрхэн нээж байгаа нь түгшүүр төрүүлдэг” гээд тэд компанийн сүлжээгээр ирсэн учир аюулгүй гэж боддог хэмээв. Хэдэн компани фишинг мэйл илгээж ажилтнуудад туршиж үзсэн байна. АНУ-ын Дотоод аюулгүй байдлын яам ажилтнууддаа Редскинз багийн тоглолт үнэгийг үзэхийг санал болгосон фишинг илгээжээ. Гэвч уг холбоосоор орсон ажилтнууд тэмцэн үзэх бас, цахим аюулгүй байдлын сургалтад заавал суух урилга хүлээн авсан байна.

Gotham Digital Science нэг үндэслэгч Жастин Кларк-Солт анхаарч дээшлүүлэхэд илүү ухаарах ёстойг онцлов. Тэрбээр хакерууд дотоод системд нэвтрэхийн тулд нэг хэрэглэгчийг л дэгээхэд хангалттай тэмдэглээд “Сүүлийн хоёр жил өндөр хэмжээний цахим гэмт хэрэг өссөн. Өмнө нь мэдэгдээгүй хуурамч илгээмжийн тоо хоёр дахин нэмэгдсэн” гэжээ. Компаниуд түүнчлэн бизнес мэйлийн хохирогч болох явдал гардаг. Цахим гэмт хэрэгтэн захирал буюу санхүүгийн хэлтсийн даргын нэрийн өмнөөс мэйл бичиж, мөнгө шилжүүлэхийг шаарддаг аж. Энэ нь дээд удирдлагын даалгаврыг хожимдуулахаас эмээх айдсыг далимдуулан гэмт этгээд өөрийн данс руу мөнгө хийлгэх арга юм.

Холбооны мөрдөх товчооны мэдээгээр 2015 онд дээрх аргыг ашигласан тоо 1300 хувиар нэмэгдэж, зөвхөн АНУ-д гурван тэрбум ам.доллар алдагдсан хэрэг бүртгэгджээ. Компаниуд түлхүүр үгийн менежер ажиллуулж, вебсайт нээхийг хязгаарлахын зэрэгцээ дотоод сүлжээнд холбох хэрэгслийг хянах боломжтой.

Цахим халдлагаас сэргийлдэг NetReveal компанийн бүтээгдэхүүний менежер Роб Нортон аюулгүйн программыг сүлжээнд суулгасан байх ёстой гэж үзэж байна. Тэрбээр “Сүлжээний аюулгүй байдлыг төлөвлөхдөө компанид ямар ч алба хашдаг хүн аюулгүй ажиллах нөхцөлийг хангасан байх ёстой. Ажилтан үйлчилгээ үзүүлэх, код бичих гэх мэт ямар ч ажил хийдэг байлаа гэсэн хариуцлагаа урамсарлах шаардлагатай” хэмээн зөвлөжээ.



## Кремлиэс жагсаал зохион байгуулсан гэв



### Катрин Хилле

ОХУ-ын Санкт Петербург хотын метронд бөмбөг дэлбэрч, 14 хүн амиа алдсан харамсалтай хэрэг гарсан. Тус улсын эрх баригчид одоо терроризмын эсрэг жагсаал олныг дайчилж байна. “Патриотки Россий” хэмээх эх оронч эмэгтэйчүүдийн бүлгэм “Терроризмын эсрэг хамтдаа” цуглааныг өчигдөр Москва хотод зарлалаа. Жагсаалыг

улам өргөжүүлж, бямба гарагт 85 хотод байгуулах аж. Москвад болох цуглаанд Ерөнхийлөгч Владимир Путинийг дэмжиж, сөрөг хүчнийг эсэргүүцдэг Үндэсний чөлөөлөх хөдөлгөөнд оролцох ажээ. “Патриотки Россий”-оос цуглаанд 10 мянга гаруй хүн ирэх төлөвтэй байгааг мэдэгдсэн юм.

Оросын 90 гаруй хотод сөрөг хүчний улстөрч Алексей Навальныйд удирдуулсан

хэдэн арван мянган хүн авлигыг эсэргүүцэн жагссан. Үүнээс 10 хоногийн дараа уг санаачилга гарсныг нь эдийн засгийн “Kommersant” сонин анхлан мэдээллээ. Дээрх нь Ерөнхийлөгч Владимир Путинийг эрхэнд гарсан 17 жилийн хугацаанд дахь хамгийн олон газрыг хамарсан, тархай жагсаал болсон байна. Мөн сүүлийн таван жилд болсон жагсаалуудаас хамгийн олон

хүнийг хамарсанд тооцогджээ.

Москва дахь Карнегийн төвийн улс төрийн шинжээч Александр Колесников терроризмын эсрэг хөдөлгөөн 2011 болон 2012 оны Кремлийн дэмжлэг бүхий жагсаалтай ижилхэн байгаа тухай ярьсан. Тухайн үед сонгууль булхайтай болсон, мөн ноён Путин дахин Ерөнхийлөгч болсон гэх шалтгаанаар Москва хотод хэдэн сараар үргэлжилсэн жагсаалыг эсэргүүцсэн бас нэгэн жагсаал байсан юм. Ноён Колесников хэлэхдээ “Тэд хүмүүсийг гудамжинд жагсаах хүч чадал, эрх мэдэлтэй гэдгээ харуулах гэж ингэж байгаа. Энэ бүгд тавилттай, хийсвэр байна” гэжээ. Хэд хэдэн хүн Кремлийн хүсэлтээр нутаг орондоо хөдөлгөөн эхлүүлсэнээ хүлээн зөвшөөрсөн. Тэд Оросын алс дорнодын захиргааны албан тушаалтан, бүс нутгийн төрийн өмчит компанийн удирдлага, зүүн хойд Карелийн бүгд найрамдах улсын хууль сахиулагчид болон эрх баригч Нэгдсэн Орос намын идэвхтнүүдийн нэрийг өгчээ.

Санкт Петербург хотын захирагч цуглаан зарласан. Бусад хэд хэдэн хотод эрх баригчид,

заримд нь ахмад дайчид, байгууллагууд, Засгийн газрыг дэмжигч залуусын төлөөлүүд, Казаки, эрх баригч нам, Засгийн газарт ээлтэй оюутны холбоо зохион байгуулжээ.

Ноён Путиний хэвлэлийн төлөөлөгч Дмитрий Песков харин Кремль жагсаал зохион байгуулаагүйг мэдэгдлээ. Тэрбээр “Кремль цуглаан зохион байгуулдаггүй. Тэгэх ч шаардлагагүй. Нийгмийн нэгдэл, эв санааны нэгдэл гэдэг нь илэрхий байна” гэсэн аж.

Хурц тод шүүмжилдгээрээ алдартай телевиз, радиогийн хөтөлгөч Сергей Доренко Кремлийг үүнд буруутгаж, Кремлийн дэргэдэх Менежийн талбайд жагсахыг уриалжээ. Өөрийнхөө удирддаг “Говорит Москва” радиогийн вэб хуудаст “Эрх баригчид цуглаан зохион байгуулж, биднийг Зөвлөлт маягаар жагсах гэж байна хэмээн олон хүн айж буй. Санкт Петербургийн хүмүүстэй эв санаа нэг буйгаа хүн бүр л илэрхийлэхийг хүсэж байгаа. Гэвч Пруссийн казарм үнэртсэн албархаг байдлаас эмээж байна шүү дээ” гэж бичжээ.



## Хөгжмийн зах зээл сэргэсэн жим

### Жон Гаппер

Канадын рэппер Дрэйкийн гуравдугаар сард гаргасан Moge Life цомог эхний долоо хоногтоо 385 сая удаа тоглогджээ. Энэ бол зөвхөн АНУ дахь үзүүлэлт. Цахимаар дуу тоглуулах явдал CD-ний борлуулалт, татаж авах, хулгайгаар татахаас ч их эрэлттэй болсон байна. АНУ-ын дуу тоглуулах зах зээл 2016 онд 3.9 тэрбум ам.доллаараар өсөж нийт 7.7 тэрбумаар хэмжигдлээ. Анх 1999 онд уг зах зээл үүнээс хоёр дахин их ашиг олж байсан ч цахим орчинд зохиогчийн эрхийг зөрчих явдал газар авснаар сөхөрсөн юм. Харин одоо эргээд эрчээ авч, дэлхийн хамгийн том хөгжмийн лейбл хөгжмийн продакшн Universal Music дуу тоглуулагч сайт Spotify-тай лицензийн гэрээ хийлээ.

Зохиогчийн эрх зөрчигчид харин цайзаа булаан эзлүүлэв. Pirate Bay сайтыг үүсгэн

байгуулагч Готтфрид Свартем “Швед бол хойд Европт байдаг улс. Америкийн хууль манайд үйлчлэхгүй” гэж мэдэгдэж байсан. Гэвч дараа нь шоронгийн хаалга татаж, Швед улсын иргэд Apple Music тэргүүтэй үйлчилгээг дэлхийн хамгийн өндөр үнээр авдаг болсон юм.

Цахим ертөнцөд зохиогчийн эрх нь зөрчигдсөн эхний бүтээлд дуу, хөгжим багтаж, хөгжмийн лейблүүд ихээхэн хохирол амсаж, дараа дараагийн үедээ сургамж болсон билээ.

Боб Диланы зөвлөснөөр бүгдийг нь битгий хая. Лейблүүд хууль бусаар дуу татаж авсан хувь хүмүүсийг шүүхэд өгч, өөрсдийгөө дээрэнгүй болгож харагдуулсан нь томоохон алдаа байсан. Гэвч тэд студийд бичүүлсэн дуу үнэ цэнэтэй, үүнийг сонсохын тулд мөнгө төлөх нь зүйтэй гэдэгт итгэл алдраагүй. Мэдээллээ үнэгүй

цацаж, рекламаас олох ашигтаа найдсан сонины эзэн шиг ухаангүй үйлдэл хийгээгүй. Ингэж итгэсэн итгэлийнхээ үр ашгийг тэд одоо амсаж, 2016 онд гэхэд л төлбөртэй дуу сонсох үйлчилгээний ашиг 1.2 тэрбум ам.доллараас 2.5 болж өслөө. Зөвхөн АНУ-д шүү дээ. Дижитал таталт, биет худалдаа багасаж байгаа энэ үед дуу тоглуулах үйлчилгээ хөгжмийн зах зээлийн гол орлогыг бүрдүүлж байна. Spotify-ийн 50 сая хэрэглэгч 30 сая дууны сангаас хязгааргүй сонсохын тулд мөнгө төлдөг. Тэд рекламаар санхүүждэг үйлчилгээнээс татгалзсан. Spotify шинэ, залуу хамтлаг дуучдыг олж, дэмжихэд нийт орлогынхоо 27 хувийг зарцуулдаг ажээ.

Хөгжмийн лейбл урьд нь их зургаа байсан бол одоо нэгдэж их гурвал болжээ. Universal, Warner болон Sony Music гурав



нийлээд зах зээлийн 75 хувийг эзэлдэг билээ. Тиймээс ч Spotify болон бусад дистрибьютортой хэлцэл хийхэд ихээхэн нөлөө үзүүлж байгаа юм. Яг л ном хэвлэх үйлдвэрүүд Amazon-ий хүчин чадалд нийцэхийн тулд нэгдэн “их тавал” болсны адил.

Сонсогчид Аделийн 19, 21, 25 цомгийг сонсохын тулд сард 9.99 ам.доллар төлдөг болохоор дуу тоглуулах үйлчилгээнд хит дуу болон хуучны сан аль аль нь хэрэгтэй. Энэ нь лейблүүдэд үнэ тохирох эрх олгож, ашиг орлогод нь ч сайн нөлөөтэй. Goldman Sachs-ийн мэдээлснээр

дижитал борлуулалтын үнэ биет бүтээгдэхүүнээс хоёр дахин их.

Дуу тоглуулах үйлчилгээ дуу сонсох явцыг илүү хөгжилтэй болгож, найзуудаараа дамжуулж шинэ дуу, хамтлаг дуучин олох ажлыг хялбарчилсан. Хөгжмийн лейблүүд бие дааж ийм бүтээгдэхүүн бүтээх боломжгүй байсан. Дашрамд дурдахад, Universal шинэ хэлэлцээндээ өөрийн лейблийн хамтлаг дуучдыг шинэ цомгоо хоёр долоо хоногоос ихгүй хугацаанд Spotify-д байрлуулах тухай заажээ.



## Эдийн засаг

ТӨЛӨВ

# Инфляцийн өсөлт үргэлжилнэ

**АХБ: Монголын эдийн засаг 2.5 хувиар өснө**

Н.Болор  
ЗГМ

Азийн хөгжлийн банк (АХБ) энэ оны дэлхийн улсуудын эдийн засгийн өсөлтийн таамгийг пүрэв гарагт танилцуулав. Энэхүү тайланд Монгол Улсын эдийн засаг энэ онд 2.5 хувь, 2018 онд хоёр хувиар өснө гэсэн хүлээлтэй байгааг онцоллоо. 2017, 2018 оны эдийн засгийн өсөлтөд уул уурхайн томоохон хөрөнгө оруулалт эергээр нөлөөлнө гэж Азийн хөгжлийн банк үзсэн байна. Ирээдүйг ажвал, манай улсын эдийн засгийн урт хугацааны төлөв эерэг хандлагатай байгааг АХБ тэмдэглэлээ.

Одоо хэрэгжиж буй уул уурхайн томоохон төслүүд нь төсвийн тэнцэл болон төлбөрийн тэнцлийг эерэг болгох хүлээлттэй байна. Байгалийн баялгаас олох орлогыг амжилттай удирдан зарцуулах нь Монгол Улсын ирээдүйн хөгжилд цаашид чухал түлхүүр болох бөгөөд эдийн засгийг төрөлжүүлэх болон өндөр бүтээмжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой гэв.

Харин эдийн засгийн өөр нэг гол үзүүлэлт болох инфляци ирэх хоёр жилд нэмэгдэх нь. Үүнд төгрөгийн ханшийн уналтаас болж импортын бараа, бүтээгдэхүүний үнэ өссөн нь үргэлжлэн нөлөөлөхөөс гадна Олон Улсын Валютын Сангийн



С.Батсайхан / ЗГМ ©

хөтөлбөрийн хүрээнд Монгол Улс шатахууны онцгой албан татвараа нэмэхээр болсон нь инфляцийг нэмэгдүүлнэ гэж таамаглажээ.

Харин нүүрсний экспорт нэмэгдсэнээр урсгал дансны алдагдал энэ онд дотоодын нийт бүтээгдэхүүний 2.1 хувьд хүрч буурах төлөвтэйг “Азийн хөгжлийн төлөв” тайланд дурдсан байна. Энэхүү тайланг Азийн хөгжлийн банк жил бүр нийтлэн гаргадаг бөгөөд эдийн засгийн гол тайлангийн нэг юм. Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах нь санхүүгийн алдагдлыг нөхөх болон нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах гол хэрэгсэл гэдгийг АХБ онцолж байна.

Азийн хөгжиж буй эдийн

» Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны төлөв байдал эерэг хандлагатай байгааг АХБ тэмдэглэлээ.

» Нүүрсний экспорт нэмэгдсэнээр урсгал дансны алдагдал энэ онд дотоодын нийт бүтээгдэхүүний 2.1 хувьд хүрч буурна.

» Шатахууны онцгой албан татвараа нэмэхээр болсон нь инфляцийг нэмэгдүүлнэ гэж таамаглажээ.

засагтай орнуудыг нийтэд нь аваад үзвэл, 2017, 2018 онд 5.7 хувиар өснө гэж тооцоолжээ. Харин Азийн орнуудын инфляцийн түвшин 2017 онд гурван хувь, 2018 онд 3.2 хувиар өснө гэсэн таамаг дэвшүүлсэн байна. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт ирэх онд саарах төлөвтэй байгааг АХБ-наас энэ үеэр мэдээлэв. Өмнөд хөршийн эдийн засаг энэ онд 6.5 хувиар өсөх ч ирэх онд энэ өсөлт бага зэрэг саарч, 6.2 хувь болно гэж урьдчилан тооцоолсон байна.

Азийн улс орнуудын гуравны хоёр нь эдийн засгийн эерэг өсөлттэй байгаа нь дэлхийн эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ оруулж буй хамгийн том тоглогч болж байгааг дээрх тайланд дурджээ. “БНХАУ илүү хэрэглээнд суурилсан эдийн засагтай болж, дэлхийг хамарсан эрдлүүдтэй тулгарч, түүнтэй зохицож байгаа хэдий ч хөгжиж буй Азийн бүс нутаг

төдийгүй дэлхийн эдийн засгийг жолоодогч хэвээр байна. Хөгжингүй орнуудын гэнэтийн бодлогын өөрчлөлтүүд тус бүс нутгийн эдийн засгийн төлөвт эрсдэл учруулж буй ч, ихэнх улс орнуудын эдийн засаг богино хугацааны болзошгүй цочролыг даван туулах бэлтгэлтэй байгаа” хэмээн АХБ-ны ерөнхий эдийн засагч Ясююки Савада тодотгов.

АНУ, Евро бүс болон Япон улсын эдийн засаг 2017 болон 2018 онд дунджаар 1.9 хувиар өсөх төлөвтэй байна. Энэ нь аж үйлдвэржсэн орнуудын эдийн засгийн өсөлт эрчимжиж байгааг харуулж байгаа ажээ. Бизнес эрхлэгчид болон хэрэглэгчдийн итгэл найдвар сайжирч, ажилгүйдэл буурсан нь АНУ-ын эдийн засгийн өсөлтөд томоохон түлхэц болсон ч цаашдын эдийн засгийн бодлогын эргэлзээтэй байдал нь энэхүү хүлээлтийг бууруулах магадлалтай гэжээ. [ЗГМ]

дэлхий

## ОХУ-ын инфляци хамгийн бага түвшиндээ хүрэв

Х.Дөлгөөн  
Шинжээч

Рублийн ханш нэмэгдсэнээс хойш таван жилийн дараа ОХУ-ын инфляци хамгийн бага түвшинд хүрлээ. Өнгөрсөн гуравдугаар сард хэрэглээний үнийн индекс өмнө оны мөн үеэс 4.3 хувиар өссөн байна. ОХУ-ын Төв банкны мэдээлснээр 2017 онд

инфляцийг дөрвөн хувьд барих бодлого баримталж байгаа юм. Түүнчлэн энэ онд рубль есөн хувиар чангарсан нь дэлхийн хөгжиж буй 24 зах зээлийн валютуудаас хоёрдугаарт жагсаж байна. Гуравдугаар сард хүүгийн түвшин буурч хүүгийн үнэлгээ 9.75 хувь хүртэл буурсныг бодлого тодорхойлогчид “инфляци тогтвортой болох хүртэл эргэлзээтэй байх болно” гэж тайлбарлаж байна.

## ЗГМ ТОВЧХОН

» ДУУДЛАГА ХУДАЛДАА

29.9

Сая ам.доллар. Монголбанк гадаад валютын дуудлага худалдаагаар 29.9 сая ам.долларыг 2437.51 төгрөгийн хаалтын ханш-тайгаар банкуудаас худалдаж авлаа.

» ТӨСӨЛ

Төрийн өмчит “Эрдэнэс Монгол” компани шингэн түлш үйлдвэрлэх төслийг хэрэгжүүлж байна. Энэхүү төслийн хүрээнд чанарын үзүүлэлт муутай хүрэн нүүрсийг үр ашигтай шингэн түлш болгон гаргаж авна.

» ТАТВАР

30

Хувь. Төсөвт төвлөрөх татварын орлого энэ оны эхний гурван сарын байдлаар 30 хувиар давж биелэв.

» ИПОТЕК

28.6

Мянга. Орон нутаг дахь банкуудын ипотекийн зээлийн үлдэгдэл 921.1 тэрбум төгрөгт хүрч, зээлдэгчийн тоо 28.6 мянга болжээ.

» УУЛ УУРХАЙ

3.7

Тэрбум ам.доллар. Уул уурхай, газрын тосны салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ 2017-2020 онд 3-3.7 тэрбум ам.долларт хэлбэлзэх урьдчилсан төлөвтэй байна.

» СУДАЛГАА

49.1

Хувь. Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд энэ сарын 6-ны байдлаар нийт өрхийн 49.1 хувь буюу 283 мянган өрх хамрагджээ.

## ВАЛЮТЫН ХАНШ

АНУ доллар	2435.25
Евро	2592.69
Япон иен	22.04
ОХУ рубль	43.17
БНХАУ юань	353.06
БНСУ вон	2.15

## МЭДЭГДЭЛ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДЭД

Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль, НӨАТ-ын тухай хууль хэрэгжиж эхэлснээр 2016 оны төсвийн татварын орлого төлөвлөснөөс 487,1 тэрбум төгрөгөөр түүний дотор нэмэгдсэн өртгийн албан татварын орлого өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 70.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ба сүүлийн 20 жилд анх удаа татварын орлого бүх төрлөөр биелсэн байна. Мөн 2017 оны эхний 3 сард татварын орлого 30%-иар давж биеллээ. Үүнээс дүгнэхэд татварын эрх зүйн орчны шинэчлэлийн системийн эхлэл тавигдаж, үр дүнд нь эдийн засаг хүндрэлтэй байгаа хэдий ч төсөвт төвлөрөх татварын орлого зөвхөн 2016 оны 1 сарын 1-нээс өнөөдрийг хүртэлх хугацаанд 800 тэрбум төгрөгөөр давсан байна.

Ийнхүү татварын суурь өргөжиж, татварын орлого бүрдүүлэхэд нааштай үр дүн гарч байгаа энэ үед Засгийн газраас төсвийн зардлыг нэмэгдүүлэх, тэтгэврийн насыг нэмэх, түүнчлэн 2016 оны намрын чуулганаар хэлэлцүүлж байсан татвар нэмэх асуудлыг Олон Улсын Валютын Сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” хэрэгжүүлэх нэрийн дор 2017 оны төсвийн тодотголтой хамт УИХ-д өргөн барьж байгаагай холбогдуулан бизнесийн төлөөлийн гол байгууллагын хувьд МҮХАУТ дараах санал, шаардлагуудыг хүргүүлж байна. Үүнд :

Төсвийн зардлыг 2017 оны батлагдсан төсвөөс огт нэмэгдүүлэхгүй байх. Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн тодотголоор нийт зарлага ба цэвэр зээлийг батлагдсан түвшнээс 220.7 тэрбум төгрөгөөр нэмсэн байна;

Төрийн захиргааны албан хаагчдийн тоог 20%, үйлчилгээний албан хаагчдийн тоог 10%-иар тус тус бууруулах. 2012 оноос хойш төрийн албан хаагчдийн тоо ойролцоогоор 15 хувь буюу 24 мянгаар өссөн байна. Мөн төрийн албан хаагчдийн шаардлагагүй зардал, нэг удаагийн буцалтгүй тусламж, тэтгэмжийг зогсоох;

Нийгмийн даатгалын шимтгэлийг нэмэгдүүлэхгүй байх. Эдийн засаг хямралтай, аж ахуйн нэгжүүдийн ашиг орлого буурсан хүнд нөхцөл байдалд НДШ-ийг нэмэгдүүлэх нь ажлын байр буурах, улмаар ядуурал ихсэх нөхцөл болно;

Хувь хүний орлогын албан татварыг нэмэгдүүлэхгүй байх;

Тодорхой салбарт дэмжлэг үзүүлэх, зарим барааны үнэ тогтворжуулах нэрийн дор зах зээлийн зарчмаар тэгш, шударга өрсөлдөх боломжийг хааж буй татварын хөнгөлөлт, чөлөөлөлтүүдийг үзүүлэхгүй байх;

Онцгой албан татварыг нэмэгдүүлэхгүй байх;

Төсвөөс татаас авдаг, алдагдал өндөртэй төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг хувьчлах, татан буулгах асуудлыг яаралтай шийдвэрлэх;

Тэтгэврийн насыг үе шаттай нэмэх асуудалд тооцоо, судалгаатай хандан шийдвэр гаргах. Энд баталгаатай ажлын байртай төрийн 183 мянга гаруй албан хаагчдийн тэтгэврийн насыг нэмэх асуудлыг төр өөрөө мэдэж зохицуулах боломжтой ч чөлөөт зах зээлд ажиллаж байгаа 1 сая гаруй иргэд баталгаагүй, тогтворгүй ажлын байранд ажилладаг гэдгийг онцгойлон анхаарах шаардлагатай. Мөн монгол хүний насжилт, салбарын онцлог, ажлын байрны нөхцөл, тогтвортой байдал зэрэг хүчин зүйлүүдийг харгалзан үзэх хэрэгтэй.

Иймд Улсын Их Хурал 2017 оны төсвийн тодотголыг хэлэлцэн шийдвэрлэхээс өмнө УИХ-ын гишүүдээс бүрдсэн ажлын хэсэг гарган дээрх шаардлагуудыг судлан шийдвэрлэхийг УИХ-ын дарга М.Энхболд, УИХ-ын эрхэм гишүүдээс шаардаж байна.

Бизнес эрхлэгчдээс тавьж байгаа эдгээр шаардлагуудыг хүлээн авч нааштай шийдвэрлээгүй тохиолдолд 2017 оны 4 сарын 10-нд төлөх 3 дугаар сарын Нэмэгдсэн өртгийн албан татвар, 4 сарын 15-нд төлөх 1 дүгээр улирлын ААНОАТ, 5 сард төлөх 4 сарын Нийгмийн даатгалын шимтгэлийг төлөхгүй байхыг нийт аж ахуйн нэгжүүдэд уриалахаа мэдэгдэж байна.

МҮХАУТ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ТЭРГҮҮЛЭГЧИД  
2017.04.05

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2017.04.07

Тендер шалгаруулалтын нэр: **ОЛОН УЛСЫН НИСЛЭГИЙН ЗОРЧИГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ЗОРИУЛЖ ГАН ХАЛБАГА, СЭРЭЭ, ХУТГА НИЙЛҮҮЛЭХ**

Тендер шалгаруулалтын дугаар: **13/2017-М**

МИАТ ХК эрх бүхий тендерт оролцогчдоос ОЛОН УЛСЫН НИСЛЭГИЙН ЗОРЧИГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ЗОРИУЛЖ ГАН ХАЛБАГА, СЭРЭЭ, ХУТГА НИЙЛҮҮЛЭХ

тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 50000 (тавин мянган) төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн [45] хоногийн дотор хүчинтэй байна.

**Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.**

**Үүнд:**

Борлуулалтын хэмжээ сүүлийн 1 жилд: 100 сая төгрөгөөс багагүй байна.

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жил: 2015, 2016 он

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:40 сая төгрөг байна.

Тендерийн хамт 1 900 000 (нэг сая есөн зуун мянган) төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 5 сарын 8-ны өдрийн 10.00 цагаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 5 сарын 8-ны өдрийн 10.30 цагт нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.


Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, ХУД, 10-р хороо, 17120 Буянт-Ухаа-45,  
МИАТ ХК. Хангамж, үйлчилгээний хэлтэс, 107 тоот.  
Харилцах албан тушаалтан Л.Гансүх, Утас: 99992742, 70049860**

# Эдийн засаг

## MSE ALL индекс 2.97 хувиар өсөж, 851.63 нэгжид хүрчээ



Монголын хөрөнгийн биржийн пүрэв гарагийн арилжаагаар ТОП-20 болон MSE ALL индекс өслөө. Тухайлбал, ТОП-20 индекс 131.70 нэгж буюу 1.04 хувиар дээшилж, 12,840.91 нэгжид хүрсэн байна.

Индексийн өсөлтийг сагсанд нь багтаж буй хөрөнгийн биржийн I болон II ангиллын

таван хувьцааны ханш дэмжив. Тухайлбал, "Говь" хувьцаат компанийн ханш 1.3, АПУ-гийнх 0.08 хувиар чангарсан байна.

Харин нийт бүртгэлтэй хувьцааны ханшийн хөдөлгөөнийг илэрхийлж буй MSE ALL индекс өмнөх хаалтаас 24.53 нэгж буюу 2.97 хувиар өсөж, 851.63 нэгжид хүрчээ. [31M]

## ХУДАЛДАНА

**ХОТЫН ТӨВД НОМИН ИХ ДЭЛГҮҮРИЙН АРД БАЙРШИЛТАЙ ШИНЭЭР АШИГЛАЛТАНД ОРОХ БИЗНЕС ТӨВД ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛБАЙ ДАВХАРААР НЬ БОЛОН ЦӨӨН ТООНЫ ОФФИС ХУДАЛДАНА.**

96028751, 99093501

MSE ALL индекс сүүлийн хоёр жилд (нэгжээр)

НЭР	СИМБОЛ	БИРЖ	ВАЛЮТ	ХАНШ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
RIO TINTO	RIO	ASX	AUD	60.68	▲ -1.69%	4/6/2017
WOLF PETROLEUM	WOF	ASX	AUD	0.034	▲ -5.56%	4/6/2017
PETRO MATAD	MATD	LON	GBX	26.125	▼ +0.49%	4/6/2017
ASPIRE MINING	AKM	ASX	AUD	0.027	▼ +22.73%	4/6/2017
GUILDFORD COAL	GUF	ASX	AUD	0.013	▼ -7.69%	4/6/2017
PROPHESY DEVELOPMENT	PCY	TSX	CAD	3.66	▲ +2.23%	4/6/2017
TURQUOISE HILL RESOURCES	TRQ	TSX	CAD	4.15	▲ -0.24%	4/6/2017
SOUTHGObI RESOURCES	SGQ	TSX	CAD	0.38	▼ -3.8%	4/6/2017
XANADU MINES	XAM	ASX	AUD	0.22	▼ +2.27%	4/6/2017
ENTREE GOLD	ETG	TSX	CAD	0.67	▲ -4.29%	4/6/2017

### ТҮҮХИЙ ЭД

НЭР	СИМБОЛ	НЭГЖ	ХАНШ (\$)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АЛТНЫ СПОТ	XAU	унци	1254.07	▼ -0.13%	4/6/2017
ЦАГААН АЛТ	PLA	унци	961	▲ +0.15%	4/6/2017
МӨНГӨ	SIA	унци	18.235	▲ +0.26%	4/6/2017
ЗЭС (COMEX)	HGA	фунт	266.8	▼ -0.45%	4/6/2017
ТӨМРИЙН ХҮДЭР	TIOA	тонн	79.44	▲ +0.1%	4/6/2017
WTI ТОС	CLA	баррель	51.02	▼ -0.25%	4/6/2017
БРЕНТ	COA	баррель	54.27	▼ -0.17%	4/6/2017
БЕНЗИН	XBA		171.27	▼ -0.15%	4/6/2017
БАЙГАЛИЙН ХИЙ	NGA	Mmbtu	3.268	▲ +0.06%	4/6/2017
НҮҮРС (NYMEX)	QZA	тонн	336.55	▲ +0.21%	4/6/2017
НҮҮРС (NEW CASTLE)	XWA	тонн	89.1	▲ +0.79%	4/6/2017
ЭЛСЭН ЧИХЭР	SBA	фунт	0.161	▼ -0.37%	4/6/2017
БУДАА	RRA	центнер	10.155	▼ -0.2%	4/6/2017
БУУДАЙ	WA	бушель	428	▼ -0.41%	4/6/2017
КАКАО	CCA	тонн	2113	▲ +0.05%	4/6/2017
КОФЕ	KCA	фунт	1.373	▼ -0.33%	4/6/2017

Энэхүү ханшийн мэдээлэл нь хүснэгтэд заасан өдрийн 15 цагийн байдлаарх дүн тул үүнээс хойш өөрчлөгдсөн байх боломжтой.



### МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АПУ ХК	APU	340.67	▲ 0.08%	4/6/2017
ГОВЬ ХК	GOV	12240	▲ 1.32%	4/6/2017
МИК ХОЛДИНГ ХК	MIK	11500	▲ 14.2%	4/6/2017
МАХ ИМПЕКС ХК	MMX	2431	▼ -0.86%	4/6/2017
СҮҮ ХК	SUU	132.06	▼ -0.35%	4/6/2017
ТАЛХ ЧИХЭР ХК	TCK	20120	▼ -6.59%	4/6/2017
АДУУН ЧУЛУУН ХК	ADL	2359	▲ 2.21%	4/6/2017
БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ ХК	BNG	40000	▼ -1.96%	4/6/2017
УБ-БУК ХК	BUK	360	▼ -0.23%	4/6/2017
АРИГ ГАЛ ХК	EER	2445	▲ 1.88%	4/6/2017
ГУТАЛ ХК	GTL	14250	▲ 3.11%	4/6/2017
ЖЕНКО ТУР БҮРӨ ХК	JTB	56	▲ 1.6%	4/6/2017
МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК	MCH	520	▼ -0.96%	4/6/2017
МАТЕРИАЛИМПЕКС ХК	MIE	8500	◀▶ 0%	4/6/2017
МОНГОЛ ШУУДАН ХК	MNP	394.67	▼ -0.08%	4/6/2017
РЕМИКОН ХК	RMC	46	▼ -6.06%	4/6/2017
ШАРЫН ГОЛ ХК	SHG	2300	◀▶ 0%	4/6/2017

Тухайн өдөр арилжаалагдсан хувьцаа

### ДЭЛХИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
NASDAQ COMPOSITE	CCMP	5864.477	-34.13 ▼ -0.58%	4/6/2017
DAX INDEX	DAX	12132.66	-84.88 ▼ -0.69%	4/6/2017
TORONTO STOCK EXCHANGE	SPTSX	15642.99	-26.09 ▼ -0.17%	4/6/2017
S&P/ASX 200	AS51	5856.285	-19.91 ▼ -0.34%	4/6/2017
S&P 500	INX	2352.95	-7.21 ▼ -0.31%	4/6/2017
SHANGHAI COMPOSITE	SHCOMP	3281.005	+10.7 ▲ +0.33%	4/6/2017
DOW JONES INDUSTRIAL AVERAGE	INDU	20648.15	-41.09 ▼ -0.2%	4/6/2017
TOP 20	MSETOP	12840.91	+131.7 ▲ +1.04%	4/6/2017
FTSE 100	UKX	7258.26	-73.42 ▼ -1%	4/6/2017
HANG SENG	HSI	24258.9	-141.9 ▼ -0.58%	4/6/2017
NIKKEI 225	NKY	18597.06	-264.21 ▼ -1.4%	4/6/2017



## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН ЧУУЛГА УУЛЗАЛТ

### ЭРХЭМ ЗОРИЛГО

Монголын хөрөнгийн зах зээлийг идэвхжүүлэх, ард иргэдэд санхүүгийн боловсрол олгох, санхүүжилт эрэлхийлж буй бизнесүүдийг хөрөнгө оруулагчидтай холбох, дэлхийн шилдэг хөрөнгө оруулагчдын туршлага, зах зээлийн чиг хандлагыг анхдагч эх үүсвэрээс нь түгээх.

### АЛСЫН ХАРАА

Хуримтлалаа ухаалгаар удирддаг хөрөнгө оруулагч үндэстэнг бий болгох.

## ПАНЕЛ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН СЭДВҮҮД

- Хөрөнгө оруулалт  
**Хувийн санхүү ба хөрөнгөө хэрхэн зөв удирдах вэ?**
- Санхүү ба Технологи  
**Дижитал хувьсгал ба Финтек**
- Хувьчлал  
**Бид сүүлийн 25 жилд хувьчлалаас юу сурсан бэ?**
- Гарааны бизнес  
**Гарааны бизнест хөрөнгө оруулахдаа ирээдүйд амжилттай байх эсэхийг нь хэрхэн танин мэдэх вэ?**

## ОНЦЛОХ ПАНЕЛИСТУУД



**Л.Энх-Амгалан**  
УИХ гишүүн  
Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны хорооны дарга



**Н.Мөнхнасан**  
Монполимет Групп  
Захирал



**Ч.Хүрэлбаатар**  
УИХ гишүүн  
Төсвийн байнгын хорооны дарга



**С.Дөлмандах**  
Хуур Мюзик Групп ХХК  
Гүйцэтгэх захирал



**Д.Цогтбаатар**  
УИХ Гишүүн



**Б.Жавхлан**  
УИХ Гишүүн

**ХААНА:** Corporate Convention Centre  
ахалсан.шилбүүр.үзвэр

**ХЭЗЭЭ:** 2017 оны 4 сарын 22  
Үргэлжлэх хугацаа: 10:00-18:00